

# 2019

## МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН  
ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ  
АЛБАДАН СУРГАЛТЫН  
ХЭРЭГЖИЛТ



Хүчирхийллийн эсрэг  
үндэсний төв



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг







**Хүчирхийллийн эсрэг  
үндэсний төв**



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг



# **ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

## **МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2019 он



## **ОРШИЛ**

### **НЭГ. МОНИТОРИНГИЙН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

- 1.1. Үндэслэл
- 1.2. Мониторингийн зорилго
- 1.3. Хамрах хүрээ
- 1.4. Арга зүй

### **ХОЁР. ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

- 2.1. Эрх зүйн орчин
- 2.2. Зохион байгуулалтын зохистой бүтцээр хангагдсан байдал
- 2.3. Сургалтыг зохион байгуулах орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн, сургагч багш нарын бэлтгэгдсэн байдал
- 2.4. Сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын төлөвлөгөө, сургалтыг явуулж буй хэлбэр, үнэлгээ
- 2.6. Төсөв, санхүүжилт
- 2.5. Сургалтын хяналт, үнэлгээ
- 2.6. Салбар дундын хамтын ажиллагаа, мэдээллийн сангийн нэгдсэн бүртгэл

### **ГУРАВ. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ**

- 3.1. Дүгнэлт
- 3.2. Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД  
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ  
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

## МОНИТОРИНГИЙН БАГ

### **Хэрэгжүүлэгч байгууллага:**

“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ

### **Тайлан бичсэн баг:**

**Ахлагч:** Ц.Алтанцэцэг - Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн хуульч профессор, дэд профессор

**Гишүүд:** С.Эрдэнэболор - Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн хуульч профессор, өмгөөлөгч, боловсрол судлалын докторант  
О.Хишигмөнх - Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны докторант

### **Мэдээллийг нэгтгэсэн:**

Н.Арвинтариа - ХЭҮТ-ийн захирал, хуульч, өмгөөлөгч

С.Байгалмаа - ХЭҮТ-ийн Хөтөлбөрийн менежер, эрх зүйч

Д.Санчир - ХЭҮТ-ийн Үйлчилгээний менежер, хуулийн зөвлөгч, эрх зүйч

### **Мэдээлэл цуглуулагчид:**

С.Батжаргал - Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч

С.Дондов - Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч

Б.Дэлгэрцэцэг - Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч

З.Ундрах - ХЭҮТ-ийн Хамгаалах байруудын сүлжээ хөтөлбөрийн зохицуулагч, нийгмийн ажлын магистр

О.Нямбаяр - ХЭҮТ-ийн Хамгаалах байрны нийгмийн ажилтан

Ч.Одончимэг - ХЭҮТ-ийн хуулийн зөвлөгч

Ц.Даваасүрэн - ХЭҮТ-ийн сэтгэл зүйч

Б.Сүндэрмаа - ХЭҮТ-ийн Дархан-Уул аймаг дахь салбарын зохицуулагч

Б.Хүрэлцэцэг - Нийгмийн ажилтан

### **Хаяг:**

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 40-р байр 03, 06 тоот

И-мэйл: [mongolcav@gmail.com](mailto:mongolcav@gmail.com)

Вэб сайт: [www.safefuture.mn](http://www.safefuture.mn)

## ОРШИЛ

Монгол Улсын хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн шүүн таслах ажиллагааны тайланд, Цагдаагийн ерөнхий газар сар тутам гаргадаг гэмт хэргийн статистик мэдээндээ тусгаж олон нийтэд нээлттэй, ил тодоор хүргэдэг. Мөн Үндэсний Статистикийн хорооноос жил бүр гэмт хэргийн судалгаа, мэдээллийг нэгтгэн дэлгэрэнгүй тайланг гаргаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлснээс хойшхи 2 жил 10 сарын хугацаанд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо жил тутам өссөн үзүүлэлттэй гарсан. Тухайлбал,

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил улсын хэмжээнд 2017 онд 4369 бүртгэгдэж байсан бол 2018 онд 5821, 2019 оны 11 сарын байдлаар 8229 бүртгэгдэж, бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоо 2017 оноос бараг 2 дахин өсчээ<sup>1</sup>.
- 2017 онд Эрүүгийн хуулийн 11.7 (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх)-д заасан гэмт хэрэг 223 бүртгэгдэж байсан. 2018 онд 210 гэмт хэрэг, 2019 онд 207 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 3 хэрэг буюу 1.4 хувиар буурчээ.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн 60 орчим хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдэж байгаа ба нийт хохирогчдын 92.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна<sup>2</sup>.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх (ГБХТ) тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан.

ГБХТ тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаагийн байгууллагад мэдээлэх явдал нэмэгдэж, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байр, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн ажлын үйлчилгээ зэрэг хуульд заасан хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрүүд шинээр үүсч хөгжиж эхэлж байна.

<sup>1</sup> ЦЕГ-ын статистик мэдээлэл 2017-2019 он

<sup>2</sup> ЦЕГ-ын гэмт хэргийн статистик мэдээ, 2019 оны эхний 11 сарын байдлаар.

Түүнчлэн хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, зан үйлд нь нөлөөлөхөд чиглэсэн хууль эрх зүйн орчин бүрдэж, практикт тодорхой алхамууд хийгдэж байна. Тухайлбал, гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сайн дурын болон албадан сургалтын талаарх зохицуулалт ГБХТ тухай хуульд тусгагдсан бөгөөд сургалтын хөтөлбөрийг эрх бүхий байгууллагуудаас батлан мөрдүүлж байна.

Хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын зохион байгуулалтын хүрээнд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2019 онд 52,5 сая төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын гэмт хэргээс урьчилан сэргийлэх зардлаас гаргаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвд баривчлагдсан хүмүүст зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулахад зориулан зарцуулсан байна<sup>3</sup>.

Гэвч ХЭҮТ-д хандсан үйлчлүүлэгчдээс өгч буй мэдээлэл болон кейс мониторингийн үр дүнгээс харахад хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчилд хариуцлага хүлээж, албадан сургалтад хамрагдсан хэдий ч засрахгүй, давтан хүчирхийлэл үйлдэж байгаа тохиолдлууд буурахгүй байна.

Иймд хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалахад үр дүнтэй нөлөөлж чадаж байгаа эсэхийг үнэлэх, уг сургалтыг явуулах чиг үүрэгтэй байгууллага, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, цаашид хуулийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөхийн тулд энэхүү мониторингийг хийлээ.

Мониторингийн үр дүн нь хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого чиглэлийг тодорхойлох, зохистой арга хэмжээг төлөвлөхөд чухал мэдээлэл болгон ашиглагдана гэдэгт итгэлтэй байна.

Мониторинг хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хүн амын сан болон мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг дэмжсэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон өөрт байгаа мэдээллээ харамгүй хуваалцаж

---

<sup>3</sup> Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2019 оны 12-р сарын 11-ны 7/5483 тоотын хэсгээс авав.



идэвхтэй оролцсон цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, төр, төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд, иргэдэд гүн талархал илэрхийлье.

## НЭГ. МОНИТОРИНГИЙН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

### 1.1. Мониторингийн үндэслэл

Монгол Улсад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхлээд 2 жил 10 сарын хугацаа өнгөрч байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, цаг алдахгүй, шуурхай таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх болон урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хуулиудад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах зохицуулалтууд болон хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлага нарийвчлан тусгагдсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна гэж заасан. Албадан сургалтын хөтөлбөр, сургалт явуулах журмыг ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/73 тоот тушаалаар баталсан.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын зорилгыг нь хорих болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, тэдний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын эерэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэх гэж тодорхойлсон.<sup>4</sup>

Сургалтын алсын хараа нь "сургалтын үйл ажиллагаа бодит үр дүнтэй байх, сургалт явуулах алба хаагч нь мэдлэг чадвартай, мэргэшсэн байх, сургалтад хамрагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх замаар гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх..."<sup>5</sup> оршино.

---

4 ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/73 тоот тушаалын 1-р хавсралт, 3.1 дэх заалт

5 ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/73 тоот тушаалын 1-р хавсралт, 6.1 дэх заалт

Хүчирхийлэл үйлдэгч зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсанаар бусдад хор хохирол учруулсан зан үйлдэлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарлах, эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засч сайжруулах чадварыг эзэмших, зан үйлээ өөрчлөх итгэл үнэмшил нь нэмэгдэх, эрсдэлгүй зан үйлд суралцах, уур бухимдлаа хянах чадварыг эзэмшсэн байх зэрэг оролцогчийн зан үйлд эерэг өөрчлөлтүүд гарах нь сургалтын хүлээгдэж буй үр дүн юм. Иймд энэхүү мониторингоор зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах орчин, нөхцөл, зохистой бүтцээр хангагдсан эсэх, сургагч багш нарын сургагдсан байдал, сургалтын хөтөлбөр, агуулга, төлөвлөгөө, сургалтын үр дүнг үнэлэх, хянах механизм, мэдээллийн урсгал, солилцоо, салбар дундын хамтын ажиллагаа зэргийг судлан үзэж, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохыг зорилоо.

## 1.2. Мониторингийн зорилго

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал хамгаалагдахад үр дүнтэй нөлөөлж чадаж байгаа эсэхийг үнэлэх, уг сургалтыг явуулах чиг үүрэгтэй байгууллага, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, цаашид хуулийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөхөд оршино.

Мониторингийн зорилго		
Мониторинг	Үр дүнг мэдээлэх	Нөлөөлөл
<ul style="list-style-type: none"> <li>Хуульчлагдсан хэм хэмжээтэй харьцуулан үнэлэх замаар зөрчил, гажуудлыг илрүүлэх;</li> <li>Хэрэгжилтийг байдлыг баримттай илрүүлэх;</li> <li>Шалтгаан нь хаана байгааг тогтоох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зөвлөмж боловсруулах;</li> <li>Мониторингийн үр дүнг шийдвэр гаргагчдад хүргэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Мониторингийн мэдээлэл, зөвлөмжид үндэслэн илэрсэн зөрчлийг засаж залруулах талаар тодорхой стратегид тулгуурласан цогц үйл ажиллагаа явуулах</li> </ul>


Мониторингийн зорилгын хүрээнд доорхи зорилтуудыг тавьсан:

- ГБХТ тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”-ын хэрэгжилтийн бодит нөхцөл байдал, үр дүнг үнэлэх;
- Хууль, журам, процедурын хийдэл цоорхойг илрүүлэн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх арга механизмыг боловсронгуй болгох нөхцөл боломж, аргачлалыг эрэлхийлэх;
- Мониторингийн үр дүнд үндэслэн шаардлагатай санал, зөвлөмж боловсруулж, улмаар, хуулийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.

### 1.3. Хамарсан хүрээ

Мониторингийн хүрээнд Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Дархан-Уул, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Өвөрхангай зэрэг нийт 10 аймаг, нийслэлийн 2 дүүргийг хамруулан мэдээлэл цуглууллаа.

Зураг 1. Хамрагдсан аймаг, дүүрэг



Мэдээлэл цуглуулагчид сонгогдсон 5 хорих анги, 1 баривчлах төв, цагдаагийн дэргэдэх 10 баривчлах байруудаас мэдээ, тоо баримт цуглуулж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, сургагч багш, ТББ-ын мэргэжилтэн нийт 145 ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, сургалтад 5 удаагийн ажиглалт хийсэн.

Шүүхийн Судалгаа, мэдээлэл, сургалтын төв, Цагдаагийн ерөнхий газар, Монгол Улсад Гэмт хэргээс Урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах

зөвлөл, орон нутгийн шүүхүүд зэрэг байгууллагуудаас холбогдох мэдээллийг цуглууллаа.

*Хүснэгт 1. Хамарсан хүрээ, түүвэрлэлт*

№	Аргууд	Ашигласан материал	Түүвэрлэлт
1	Мэдээ, тоо баримт цуглуулах	Асуумжийн хуудас	10 аймаг, сонгогдсон 5 хорих анги, 1 баривчлах төв, баривчлах байр 10
2	Сургалтын явцад ажиглалт хийх	Ажиглалтын хуудас	5 удаагийн ажиглалт
3	Ярилцлага	Хавсралт 3, 4	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч-25 Сургалтад хамрагдсан хүчирхийлэл үйлдэгч-47
4	Сургагч багш нартай ярилцлага хийх	Фокус бүлэг Ганцаарчилсан Хавсралт 5	14 удаа/45 хүн 28 хүн
5	Мониторингийн тайлангууд	Хавсралт	Мониторинг хийсэн 16 газраас тайлан, холбогдох бичиг баримт
6	Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх	Үнэлгээний хуудас	Хорих анги, баривчлах төв, баривчлах байрууд
7	Мэдээлэл цуглуулагчийн ажиглалт хийсэн тэмдэглэл	Хавсралт	Мэдээлэл цуглуулагчийн 14 тэмдэглэл

#### **1.4. Арга зүй**

Мониторинг хийхдээ тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан явуулав.

**Баримтын дүн шинжилгээ:** Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан эрх зүйн баримт бичиг, тушаал шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, сургалтын хөтөлбөр, гарын авлага, материал зэргийг судлав.

Ганцаарчилсан ярилцлага: Урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсыг ашиглан гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдсан хүчирхийлэл үйлдэгч нартай ганцаарчилсан ярилцлагуудыг хийлээ.

**Асуулгын арга:** Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулж буй төрийн алба хаагч, төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдээс албадан сургалтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шаардагдаж буй дэмжлэгийн талаар урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу мэдээлэл цуглуулав.

**Фокус бүлгийн ярилцлага:** Асуулгын судалгаагаар авсан зарим асуудлыг гүнзгийрүүлэн тодруулах, хэрэгцээ, санал бодлыг сонсох зорилгоор фокус бүлгийн ярилцлагыг холбогдох төрийн алба хаагч, мэргэжилтнүүдийн дунд явууллаа.

**Ажиглалтын арга:** Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтийн бодит байдалтай танилцаж, сургалт явагдаж буй орчин нөхцөл, сургалтын явцад ажиглалт хийлээ.

**Тоон судалгаа:** 3 төрлийн асуулгыг ашиглан 100 хүнийг хамруулсан тоон судалгаа хийлээ.

**Чанарын судалгаа:** Ганцаарчилсан ярилцлагын арга, бүлгийн ярилцлага болон ажиглалтын аргуудыг ашиглан чанарын судалгааг хийсэн.

## ХОЁР. ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

### 2.1. Эрх зүйн орчин

Монгол Улс Үндсэн хуульдаа заасан "...хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх", Олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн "хүний эрхийг бүх түвшинд хангах" үүргийнхээ дагуу 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг, 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг тус тус батлан хэрэгжүүлжээ.

Уг хуулийн хэрэгжилтийн байдалд 2013 онд АНУ-ын Минессота мужийн Хүний эрхийн өмгөөлөгчдийн байгууллага /Minnesota Advocates for human rights/ нь Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвтэй хамтран мониторинг хийсэн байна. 2005-2013 онуудад хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд Хууль зүйн үндэсний хүрээлэн, УДШ-ийн судалгааны төв, ХЭҮТ, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагууд 20 гаруй судалгаа, дүн шинжилгээ хийж, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сан, Conrad N.Hilton сан, Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд ба хөгжил сангаас боловсруулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хууль, Албани, Япон, Өмнөд Америк, Филиппин, Вьетнам, Тайвань зэрэг олон улс орны ГБХТ тухай хууль, түүний практик хэрэгжилт, дэвшилтэт загваруудыг судалжээ.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжүүд, хууль үйлчилсэн хугацааны туршлага, сургамж, ГБХТТ хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад үндэслэн уг хуулийг 2016 онд бүхэлд нь шинэчлэн найруулж баталсан байна.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр бодлогын олон тооны баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж иржээ. Тухайлбал:

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, давтан зөрчил гаргуулахгүй байх зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтын журам, хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг хэрэгжүүлэхээр тусгасан<sup>6</sup>;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт "...гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлого үйл ажиллагааг

---

6 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010) 3.4.4.1

дэмжинэ, гэр бүлийн харилцааны нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх талаар соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлнэ”<sup>7</sup>;

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ”<sup>8</sup>;
- Монгол Улсын Засгийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрт “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа сайн дурын ажилтнуудыг дэмжих, урамшуулах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлийг өөрчлөх сайн дурын болон албадан сургалтыг тогтмол зохион байгуулах, хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлнэ” хэмээн тус тус заажээ.

Хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах хууль зүйн үндэслэл, журмыг доорхи хууль, эрх зүйн актуудаар тогтоосон байна:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 26 зүйлийн 26.3-д “Гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно.”
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд “Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй<sup>10</sup> байна”, Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална<sup>11</sup>.
3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.6-д “эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг

---

7 Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр (2017) 2.6.1, 2.6.5

8 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2016) 3.4.2

9 Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” 2017.09.20 №270 3.4.4.7, 3.4.4.8

10 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 44.1

11 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 44.4, 44.5



сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулна.”

4. Зөрчлийн тухай хуульд “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашилах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна<sup>12</sup>”
5. Эрүүгийн хуульд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ<sup>13</sup>. “Шүүх ...ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж ...зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэж болно<sup>14</sup>”
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна<sup>15</sup>.” Хорих анги нь ... гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн ...хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна<sup>16</sup>. Мөн хуулийн 189, 192, 222 дахь зүйлийн 222.1 дэх хэсэг заасан “Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх”, “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх”, “Хорих анги дахь албадан сургалт”;
7. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 тоот тушаалаар батлагдсан “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”.

---

12 Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт

13 Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.1, 7.3 дугаар зүйлийн 2.2 ишлэлийн бичвэр ялгаатай байна.

14 ШШГ тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5 дахь хэсэг

15 ШШГ тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.1 дэх хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь дээрх хууль зүйн үндэслэл, журмаас гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, баривчлах төвд дараах журам, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/169 дугаар тушаалаар батлагдсан "Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам";
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга нарын хамтарсан 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А-170/А-0138 дугаар тушаалаар батлагдсан "Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам";
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан "Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр".

## **2.2. Зохион байгуулалтын зохистой бүтцээр хангагдсан байдал**

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулах, сэтгэл зүйд нөлөөлөх, сөрөг зан үйлийг нь засах, гэр бүлийн асуудлаа эв зүйгээр шийдвэрлэх арга замд суралцуулах зорилготой хууль болон журмын зохицуулалтын үр дүн нь сургалт явуулах орчин нөхцөл, сургалтыг явуулах сургагч багш нарын үр чадвар, сургалтын оновчтой хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүнээс ихээхэн хамаарч үр нөлөөгөө үзүүлэх бөгөөд гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, давтан зөрчил үйлдэхээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

ГБХТ тухай хуульд "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна"<sup>17</sup> гэж заасан.

Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалт зохион байгуулахтай холбоотой харилцааг "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам"<sup>18</sup>-аар зохицуулж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага нь

---

<sup>17</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 44.4

<sup>18</sup> ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалын 1.2 дахь заалт

хорих болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг сургах нөхцөлөөр хангах үүрэг хүлээсэн.

Дээрх зохицуулалтуудын дагуу Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг цагдаагийн байгууллага, хорих болон хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тус хэрэгжүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжүүд нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг хариуцан зохион байгуулах<sup>19</sup> үүрэгтэй. Эдгээр байгууллагууд нь оролцогчдыг албадан сургалтад бүрэн хамруулах, хэрэв оролцогч албадан сургалтад хамрагдах үүргээ биелүүлээгүй бол холбогдох арга хэмжээ авах үүргийг хүлээсэн<sup>20</sup>. Мөн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журмаар сургалт хариуцсан ажилтан, багш, сургалтын ажилтны хүлээх үүрэг, албадан сургалтын төлөвлөгөөний бүтцийг тогтоосон.

ШШГЕГ газар болон ЦЕГ-ын харьяа хорих, баривчлах байруудад зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хариуцан зохион байгуулж байгаа байдлаас дүгнэхэд ихэнх аймгуудын хорих анги, баривчлах байруудад сургалтын орчин бүрдээгүй байгаа нь сургалт зохион байгуулахад ихээхэн бэрхшээл үүсгэж байна.

Сургалт явуулж байгаа алба хаагчдыг авч үзвэл:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиуд, Баривчлах төвд шийдвэр гүйцэтгэгч, хорих ангийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд;
- Орон нутгийн Цагдаагийн хэлтсүүдэд сургалт, соён гэгээрүүлэх хэлтэс, нийтийн хэв журам хамгаалах тасаг, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан урьдчилан сэргийлэх хэлтсийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, баривчлах, саатуулах, эрүүлжүүлэх байрны эмч зэрэг алба хаагч, мэргэжилтнүүд сургалтыг хариуцан явуулж байна.

---

19 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 1 хавсралтаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 4.1-4.3

20 “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 4.1-4.3

ГБХТ тухай хуульд зааснаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь харьяа агентлаг, байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих<sup>21</sup> чиг үүрэгтэй боловч зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж байгаа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод албадан сургалт явуулах чиг үүрэг тусгагдаагүй байна.

Албадан сургалтыг магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж болно<sup>22</sup> гэж заасны дагуу төрийн бус байгууллагуудыг сургалт явуулахад тодорхой хэмжээгээр татан оролцуулжээ.

### **2.3. Сургалтыг зохион байгуулах орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн, сургагч багш нарыг бэлтгэсэн байдал**

ШШГЕГ, ЦЕГ-ын харьяа нэгжүүд нь сургалт явуулах орчин бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

Сургалт явуулж байгаа байгууллагуудын сургалтын орчин, нөхцөл харилцан адилгүй байна. Цагдаагийн байгууллага дээр албадан сургалт явуулж буй орчин ШШГЕГ-ын харьяа хорих анги, баривчлах төвд явагдаж буй сургалтын орчинг бодвол илүү хүндрэл бэрхшээлтэй байна. Жишээ:

Манайд сургалтын анги танхим байхгүй учир баривчлагдсан байранд нь, унтаж буй нааран дээр нь суулгаад хичээлээ ордог. Аюулгүй байдал талаасаа эрсдэлтэй байдаг.

Дорнод аймаг

---


21 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 11

22 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 44.2

Зураг 1. Цагдаагийн байгууллагын албадан сургалт явуулж буй орчин, нөхцлийг харьцуулсан байдал

Хэнтий аймаг	Өмнөговь аймаг
	
<p><i>Тайлбар: Тур саатуулах өрөөнд сургалт ордог. Зуны улиралд гадаа ордог</i></p>	<p><i>Сургалтын өрөө нь тохилог, тоног төхөөрөмжөөр хангагдсан</i></p>

Зураг 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албадан сургалт явуулж буй орчин, нөхцөл

Хөвсгөл аймаг	Баянхонгор аймаг
	

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийн зорилгыг хангахад сургалт явуулах алба хаагчдыг мэргэшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын үр чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтад тогтмол хамруулах явдал чухал ач холбогдолтой. Сургалтад тогтмол хамруулснаар сургалтыг явуулах албан хаагч нь мэдлэг чадвартай, мэргэшсэн байх гэсэн шаардлага хангагдаж хууль болон журмын хэрэгжилт хангагдах ёстой. Энэ хүрээнд ШШЕГ-аас 2019 онд Монгол Улсын Багшийн Их сургуулийн харьяа “Сэтгэл зүйн үйлчилгээний төв”-тэй хамтран эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч болон Баривчлах төв, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын нийт 49 алба хаагчдад зан үйлд нөлөөлөх сургалт явуулах

эрх олгох сургалт зохион байгуулж, “Сургагч багш”-ийг бэлтгэж гэрчилгээ олгожээ<sup>23</sup>.

Тоон үзүүлэлтээс харахад 18000 орчим алба хаагч сургагдсан, Хууль сахиулах их сургуулийн харьяа Цагдаагийн сургууль, Ахлагчийн сургуулийн сургалтын хөтөлбөр, холбогдох дүрэм, журам батлагдсан байгаа зэрэг үр дүн харагдаж байгаа<sup>24</sup> ч алба хаагчдыг давтан сургах, үр чадвар олгох, мэргэшүүлэх сургалтын явц тогтмол биш, шуурхай удирдлагыг бүхэлд нь хамруулж чадаагүй, алба хаагчдад зориулсан сургалт нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөгүй, сургалтын дийлэнх нь зөвхөн хуулиар хүлээсэн чиг үүргийг танилцуулах мэдээлэл хүргэх төдий хүрээнд хийгдэж байна.

Сургагч багш нарыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу бэлтгэдэг албан ёсны байгууллага байхгүй. “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэн 2017-2018 онуудад зан үйлийг засах сургалт явуулж байсан. IDLO олон улсын байгууллага нь төслийн хүрээнд сургалт зохион байгуулж байсан.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл*

*Хэнтий, Хөвсгөл аймаг, Хорих 409-р анги*

Яг мэргэжлийн дагнасан сертификат авсан сургагч багш байхгүй. Одоогоор сургалтыг цагдаагийн газар, аймгийн гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, дээрээс нь архи дан согтуурахын эсрэг ажилладаг ТББ-ын мэргэжилтэн, сэтгэц наркологийн тасгийн эрхлэгч, эмч нарын нөөц боломжид тулгуурлан зохион байгуулж байна.

*Дархан-Уул аймаг*

Мониторингийн хүрээнд ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан 73 сургагч багшаас 16 нь буюу 20% нь төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад хамрагджээ. Үүнд:

- Олон улсын эрх зүйн байгууллага (IDLO)-аас зохион байгуулсан сургалтад хамрагдсан 5, “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнгийн сургалтад 7, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв”, “Донтолтоос эдгээх сургалт зөвөлгөөний институт”, МУИС-ийн “Нийгмийн ажлын танхим”, “Сэтгэл судлалын үндэсний төв”-өөс зохион байгуулсан сургалтад-2, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисоос хамаарал бүхий иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, үзүүлэх чиглэлээрх сургалтад 2 багш хамрагдсан байна.

23 ШШГЕГ-ын тайлан

24

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хариуцан зохион байгуулах тогтвортой боловсон хүчин, хүний нөөц дутмаг, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа мэргэжилтэн хомс байна.

Сургагч багшийн нөөц байхгүй. Ганц бэлтгэгдсэн хүн нь Цагдаагийн байгууллагаас гарчихсан.

*Фокус бүлгийн ярилцлага-Завхан аймаг*

Зан үйлд нөлөөлөх сургалтыг орон нутагт эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нар зохион байгуулж байгаа нь учир дутагдалтай байна. Учир нь тэд багшлах буюу заах арга зүй эзэмшээгүй, мэргэжлийн бус, мөн ажлын ачаалал ихтэй байдаг учраас сургалтын үр дүнд сөргөөр нөлөөлж, хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна<sup>25</sup>.

Ялангуяа орон нутагт хүн ам цөөтэй, нэгнийгээ таньдаг байдал нь сургалт явуулж буй багшид хүндрэлтэй байдаг байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахад хүчирхийлэл үйлдэгч нь сургалт явуулж байгаа багшийг хэдэн үеэр нь мэддэг. Тэдний годгоносон охин надад юу заах юм гэсэн байртай үл ойшоон харьцдаг.

*Фокус бүлгийн ярилцлага -Баян-Өлгий аймаг*

Сургагч багш нар зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулахад тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагаа тодорхойлсон байдлыг авч үзвэл:

- Сургалт хариуцсан сэтгэл зүйч, багш нарыг тусайлан бэлтгэх;
- Сургагч багш нарт зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулах;
- Сургагч багшийг орон нутагт нь дагалдуулан сургаж мэргэшүүлэх;
- Албадан сургалтын төсөв, санхүүжилт, зардлын асуудлыг шийдэх;
- Үндэсний цөөнх оршин суудаг нутаг дэвсгэрт сургагч багшид тулгардаг хэлний бэрхшээл, орчуулагч, хэлмэрчийн асуудлыг шийдэх;
- Үндэсний цөөнхийн хэл дээрх сургалтын материал, хэрэглэгдэхүүнээр хангах.

#### **2.4. Сургалтын байр, анги танхимын нөхцөл байдал, хүртээмж**

Албадан сургалтад явуулах чиг үүрэг бүхий байгууллагууд нь сургалтын төрөл, гэмт хэрэг, зөрчлийн шинж байдлаас нь хамааран оролцогчдод сургалтыг ялгамжтай байдлаар зохион байгуулах, ганцаарчилсан болон

---

25 Тайлан

бүлгийн сургалт явуулах танхимтай байх, бясалгалын өрөөтэй байх шаардлагатай<sup>26</sup>.

Судалгаанд хамрагдсан 16 газраас 5 нь зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах сургалтын анги, танхимтай байна. Үүнд: Өмнөговь, Баян-Өлгий, Хөвсгөл аймгийн болон ШШГЕГ-ын харьяа хорих 409-р анги, Баривчлах төв зэрэг газруудыг дурьдаж болно. Баян-Өлгий аймагт “Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас сургалтын өрөөг тохижуулж өгчээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвд НҮБ-ын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дагуу зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах зориулалтын байр, танхим тохижуулах ажлыг гүйцэтгэж байгаа нь сайшаалтай.

Гэвч судалгаанд хамрагдсан орон нутгийн Цагдаагийн хэлтсүүдийн дэргэдэх баривчлах байруудын ихэнх нь сургалтын өрөө танхим байхгүй байна.

• Сургалт явуулах өрөө, танхим байхгүй. Жижигхэн өрөөнд 4-5 хүн суухаар сургагч багш нь суух боломжгүй, зогсож хичээлээ ордог.

*(Завхан аймаг)*

• Сургалтын өрөө байхгүй, эрүүлжүүлэхийн эмчийн өрөө болон гал тогооны өрөөнд ордог.

*(Хөвсгөл аймаг)*

• Цагдаагийн байгууллага дээр байрны хүртээмжээс шалтгаалаад сургалтын тусгайлсан өрөө, танхим байхгүй

*(Хэнтий аймаг)*

• Сургалтын өрөө, танхим байхгүй. Өрөө танхимын хувьд ямар ч боломжгүй.

*(Говь-алтай аймаг)*

Хэдийгээр сургалт явуулах өрөө танхим байгаа ч зарим газрын сургалт явуулж буй танхим нь багтаамж муутай учир сургалтыг ярилцахаас өөр хэлбэрээр явуулах боломжгүй, сургалтын өрөө хүрэлцдэггүй зэрэг хүндрэл тохиолддог байна.

Сургалтын анги, танхимгүй газруудад түр саатуулах өрөө, баривчлагдсан хүмүүсийн байрладаг өрөө, эмчийн өрөө, номын сан, гал тогоо зэрэг

---

26 ХЗДХ сайдын 2017 оны А/73 дугаар тушаалын 4.1




зориулалтын бус газарт сургалт явуулж, зуны улиралд гадаа зохион байгуулж байгаа нь сургалтын зорилгыг хангахад сөргөөр нөлөөлж, үр нөлөөг бууруулахад хүргэж байна.

## 2.5. Сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан байдал

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрт “Абадан сургалтыг явуулахдаа компьютер, проектор, ном, гарын авлага, бусад материал, хөгжим, дүрс бичлэг зэрэг хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийг ашиглан зохион байгуулна”<sup>27</sup> гэж заасан.

Хүснэгт 1. Сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан байдал



Судалгаанд хамрагдсан 16 газраас техник тоног төхөөрөмжийн хувьд 15 нь компьютертэй, 8 нь проектортой байгаа бол сургалтын бусад хэрэглэгдэхүүний хувьд 6 нь сургалтын гарын авлага, ном бусад материалтай, 7 нь сургалтад ашиглах хөгжим, дүрс бичлэгтэй байна.

Хэдийгээр сургалт явуулж байгаа байгууллагуудын 1-ээс бусад нь компьютерээр хангагдсан сайн тал байвч 50% нь проекторгүй, хичээлийн бусад хэрэглэгдэхүүнээр хангагдаагүй нь сургалтыг үр дүнтэй явуулахад сөргөөр нөлөөлөх үзүүлэлт юм.

- Проктер, дэлгэц гэх мэт техник тоног төхөөрөмж байхгүй. *Завхан аймаг*
- Манайх тохилог өрөөтэй хэдий ч сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй. *Баян өлгий аймаг*
- Сургалтын бусад хэрэглэгдэхүүний хувьд тарааж өгөх материал байхгүй. *ШШГЕГ-ын харьяа хаалттай хорих 409-р анги*

27 ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалын 7.2 дахь хэсэг

• Техник тоног төхөөрөмж проектор, өсгөгчөөс өөр зүйл одоогоор байхгүй. Сургагч багш нь сургалтын хэрэглэгдэхүүнээ өөрөө бэлтгэж хичээлээ ордог.

*ШШГЕГ-ын баривчлах төв*

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахад ашиглаж буй сургалтын гарын авлага, арга зүйн материалууд нь хорих, баривчлах байруудад харилцан адилгүй, заримд нь сургалтын гарын авлага огт байхгүй байна.

Хорих анги, байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, баривчлах төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан гарын авлага, ашиглах материал хангалтгүй байгаа нь сургалтын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна<sup>28</sup>.

Сургалтын гарын авлага материалууд нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын эерэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэх хөтөлбөрийн зорилготой<sup>29</sup> нийцсэн байх шаардлагатай. Сургалтад ашиглаж байгаа гарын авлагууд нь бэлгийн боловсрол олгох, архины хамаарлаас гарахад туслах, сэтгэл зүй, стрессийг зохицуулахад чиглэсэн агуулгатай байна.

Манайх “Монгол өрх” сэтгэл заслын холбооноос боловсруулж гаргасан сургалтын гарын авлагыг ашиглаж сургалтаа явуулдаг. Уг гарын авлага нь ахисан түвшний сургалтад ашиглахаар бэлтгэгдсэн, илүү онол талаасаа бичигдсэн, сургалтыг явуулах арга, аргачлал байхгүй учир ашиглахад хүндрэлтэй байдаг.

*Фокус бүлгийн ярилцлага, Хаалтай хорих 409-р анги*

Сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүний хүртээмж үнэхээр хангалтгүй байна. Ямар ч байсан сургалт хийгдэж байгаа, гэхдээ чанартай гэж хэлэхэд хэцүүхэн л байна.

*Фокус бүлгийн ярилцлага, Дархан-Уул аймаг*

28 Тайлан

29 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр 04-ний өдрийн А/73 дугаар тушаалын нэдүгээр хавсралт “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 3.1

Сургалтад ашиглаж буй гарын авлага, арга зүйн материал

№	Нэр	Байгууллага	Агуулга	Зорилтот бүлэг
1	Зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааны үйл ажиллагааг төлөвлөх / гарын авлага/ 2006	НҮБ-ын хүн амын сан	Зан үйлийг өөрчлөх харилцааны талаар үр дүн дээр суурилсан хөтөлбөрийн хүрээний зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааг төлөвлөх, үнэлэх, зааварчлага	Энэ чиглэлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх цогц арга хэмжээний талаар арга зүйг сургалтад ашиглах.
2	Сэтгэл зүй, оюун санааны эмчилгээний хөтөлбөр 2009 /Минессота загвар/	Эрүүл мэндийн яам /сэтгэцийн эрүүл мэндийн нэгдсэн төв/	Архины шалтгаант сэтгэц зан үйлийн эмгэг	Архинд донтох өвчтэй хүмүүст зориулсан сургалтыг зохион байгуулах.
3	Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамж / нотолгоонд суурилсан аргачлал/ 2018	НҮБ-ын боловсрол шинжлэх ухааны байгууллага	Бэлгийн цогц боловсролын талаарх цогц ойлголт мэдээлэл үнэлгээ Үндсэн ухагдхуун сэдэв болон суралцахуйн зорилт үр дүнгийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ	Сургалтын хөтөлбөр боловсруулах хяналт-шинжилгээ үнэлгээ хийх арга зүйн болон бэлгийн чиглэлээр мэдлэг олгоход ашиглах

4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр 2011	IDLO Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага	Чадавхжуулах сургалтын хөтөлбөр	- Сургалтын хөтөлбөр, танилцуулга - Хөтөлбөрийн агуулга - Цогц ажилчдад зориулсан хөтөлбөр -Практикт зориулсан хөтөлбөр
5	Өөрийгөө өөрчилье /гарын авлага/	Хууль зүй дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	Гэр бүл, архины хор хөнөөл, стресс болон сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх тухай	Сургалтын хөтөлбөр боловсруулах болон сургагч багш нар сургалтанд хэрэглэгдэхүүн болгон ашиглах
6	Үр нөлөө бүхий бодлогын баримт бичгийг боловсруулах нь /төв ба зүүн азийн орнуудын бодлогын зөвлөхүүдэд зориулсан гарын авлага/ 2003	Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, орон нутгийн засаглал ба төрийн үйлчилгээний шинэчлэлийн санаачилга	Төрийн үйлчилгээний шинэчлэлийн хүрээнд үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэхэд анхаарах, зөвлөмж болгосон гарын авлага	Бодлогын хэмжээнд сургалтын журам хөтөлбөр боловсруулахад хэрэглэх
7	Сургагч багшийн гарын авлага 2018	Хууль зүй, дотоод хэргийн яам	Архины үр нөлөө, эрүүл мэндийн боловсрол, стрессыг даван туулах арга замын талаарх зөвлөгөө	Сургалтын хөтөлбөр боловсруулах болон сургагч багш нар сургалтанд хэрэглэгдэхүүн болгон ашиглах

## **2.6. Сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын төлөвлөгөө, сургалтыг явуулж буй хэлбэр, үнэлгээ**

*Сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын хөтөлбөр*

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох журамд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлийг засах сургалтын хөтөлбөр, агуулгыг баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ. Сургалтад оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулна, шүүхээс албадан сургалтад хамруулахаар заасан хугацааг харгалзан сургалтыг явуулж<sup>30</sup> баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтыг шүүхээс тогтоосон албадан сургалтын цагтай уялдуулан харилцан адилгүй тогтоож болох<sup>31</sup>-оор тус тус заасан байна.

ШШГЕГ нь “Гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн боловсролыг дэмжих төв” төрийн бус байгууллагатай хамтран “Зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд цахим сургалт зохион байгуулах хөтөлбөр”-ийг 2018 оны 12 дугаар сард, “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран “Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэж, зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд сургалт зохион байгуулах хөтөлбөр”-ийг 2019 оны 01 дүгээр сард тус тус баталжээ.

Цагдаагийн байгууллагад зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг “сургалтын төлөвлөгөө”, “сургалтын график”, “календарчилсан төлөвлөгөө” гэх мэт янз бүрийн баримт бичгийн хүрээнд, харилцан адилгүй батлан мөрдөж байна. Энэ нь албадан сургалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын сургалт зохион байгуулж байгаа нэгж, хүний нөөц, сургалтын орчин нөхцлөөс хамаарч байна.

Ихэнх аймаг дахь албадан сургалтыг хэрэгжүүлж байгаа алба, нэгжүүд зан үйлд нөлөөлөх албадан сургалтын нэгдмэл баримт бичиг боловсруулж, батлан мөрдөхгүй байна. Жишээ “зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”, “сэдэвчилсэн болон календарчилсан төлөвлөгөө”, “хичээлийн хөтөлбөр” гэх нэршилтэй сургалтын баримт бичгүүдэд зан

---

30 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 1 хавсралтаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 5.1.2

31 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 1 хавсралтаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 9.1

үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг зам тээврийн зөрчил, хар тамхи, мансуурах дон г.м өөр албадан сургалтын хөтөлбөрийн агуулгатай холих, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинж байдалд нийцээгүй цаг, сэдвийг хатуу тогтоох зэргээр тусгаж баталсан нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/73 тушаалаар батлагдсан журам, хөтөлбөрийн агуулгад бүрэн нийцэхгүй, сургалтын үр өгөөжийг үнэгүйдүүлэх эрсдэлтэй байна.

Сургалт явуулах байгууллагууд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг албадан сургалтад хамруулах сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөр баталсан боловч харилцан адилгүй, өөр өөр сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хэнтий, Хөвсгөл аймаг, хорих 409-р ангийн сургагч багш нар Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэн, IDLO олон улсын байгууллагаас төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтын үед тараасан гарын авлагыг ашиглаж хөтөлбөрөө боловсруулжээ.

Зарим аймгийн албадан сургалтын хичээлийн хөтөлбөр нь зорилтот бүлэг рүү чиглэсэн, цаг, сэдэв, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын залгамж холбоо сайтай, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан албадан сургалтын хөтөлбөртэй уялдсан байхад дийлэнх хөтөлбөр нь зорилтот бүлгээ ангилаагүй, өөр албадан сургалтын хөтөлбөртэй холилдсон, сэдэв хоорондын уялдаа муу, сургалтын заах арга зүй, хэрэглэгдэхүүн хөтөлбөрт тусгагдаагүй, сэдвүүдийн залгамж холбоо муу байлаа.

Сайн жишээг дурьдвал: Өмнөговь аймгийн Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрт сургалтын зорилго, хамрах хүрээг тодорхойлсон, бүлэг сэдэв, дэд сэдвүүдийг ангилсан, сургалтыг заах цаг, сургагч багшаа тодорхой тусгасан, сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн зэргийг сэдэв бүрээр гаргасан.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын даргын баталсан “Захиргааны журмаар баривчлагдсан хүмүүжигч нарын зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хуваарь” нь албадан сургалтын сэдвийг өдөр бүр лекц 1 цаг, дадлага 2 цаг, нийт 3 цаг байхаар хуваарилж, сургалтыг бүтэн жилийн хугацаанд тасралтгүй явуулахаар урьдчилсан төлөвлөсөн зэрэг сайн талтай байв. Гэвч сургалтын хуваарьт тусгагдсан сэдвүүдийг авч үзвэл “Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх”, “Согтууруулах ундааны хор уршиг”, “Архинд донтолт”, “Хөдөлгөөний аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх нь” г.м-ээр тусгасан нь агуулгын түвшинд зорилтот бүлэгт чиглүүлэн

ангилагдаагүй байна. Ингэснээр зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүн нь хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд эерэг өөрчлөлт авчирсан байх сургалтын үндсэн зорилготой нийцэхгүй байна.

Хүснэгт 2. Батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй эсэх



*Сургалтын хэлбэр*

ХЗДХЯ-наас батлагдсан сургалтын хөтөлбөрт зан үйлд нөлөөлөх сургалт нь ганцаарчилсан, бүлгийн, хосолсон хэлбэрээр байж болохоор заасан хэдий ч нийт сургалтын 92 хувь нь бүлгийн хэлбэрээр<sup>32</sup> зохион байгуулагдаж байна. Ганцаарчлан уулзах цөөхөн тохиолдол гарсан ч сургалтын бус агуулгатай, оролцогчийн сэтгэл зүйн байдал, зан харилцааг танин мэдэх шинжтэй байв.

2019 онд Баривчлах төвд нийт 7815 этгээд баривчлагдсанаас гэр бүлийн хүчирхийллийн зөрчлөөр 4631, давтан гэр бүлийн хүчирхийллээр баривчлагдсан 57 этгээдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулжээ. Энэ хугацаанд танхимын сургалтаар 7815 баривчлагдсан этгээдэд 13784 цаг, ганцаарчилсан сургалтаар 302 этгээдэд 302 цаг, бие даалтаар 41153 цаг, хөгжим /зарлан мэдээлэх систем/ ашиглан 75804 цагийн сургалтыг зохион явуулсан байна<sup>33</sup>.

Баривчлах төв нь “Гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн боловсролыг дэмжих төв” төрийн бус байгууллагатай хамтран “Зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд цахим сургалт зохион байгуулах хөтөлбөр”-ийг баталж 2018 онд орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хяналтад байгаа давхардсан тоогоор 408 этгээдэд цахим сургалтыг зохион байгуулжээ.

32 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 1 хавсралтаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 7.1

33 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, нэгжид зохион байгуулагдаж байгаа зан үйлд нөлөөх албадан сургалтын талаарх 2020 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн тайлангаас.

Бөөнөөр нэг танхимд суулгаж байгаад хичээл ордог. Танхим нь цуурайтаад багшийн яриа сайн сонсогддоггүй. Араар суусан тохиолдолд хичээлийг сонсож ойлгох ямар ч боломжгүй байдаг.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс*

Хуулийг спикерээр шөнөжин ч хамаагүй сонсох байдлаар явуулж байгаа нь залхаан цээрлүүлэлттэй адил мэдрэмж төрүүлж байв.

*Мэдээлэл цуглуулагчийн ажиглалтын тэмдэглэлээс*

Одоогийн үйлчилж буй хуулиудад 6 төрлийн 12 үйлдэлд зөрчил<sup>34</sup> үйлдсэн этгээдийг албадан сургалтад хамруулах албадлага хэрэглэхээр тусгагдсан. Үүнээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн дараах дөрвөн төрлийн үйлдэлд зөрчлийн хуулиар албадан сургалтад хамруулахаар тусгасан байна. Үүнд:

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

- Зодсон;
- Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;
- Бусадтай харилцахыг хязгаарласан;
- Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр заасан. Дээрх 4 төрлийн зөрчил үйлдсэн этгээдэд явуулах зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийн агуулга нь ялгамжтай байх эсэх талаар хууль болон хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Зан үйлд нөлөөлөх сургалтын үндсэн зорилго нь тухайн зөрчлөө давтан үйлдэхгүй байх зан үйлийн эерэг өөрчлөлт гаргахад чиглэнэ.

Сургалтын хөтөлбөр, агуулгыг тухайн оролцогч албадан сургалтад анх удаа, эсхүл давтан хамрагдаж байгаа эсэхээс нь хамааран ялгаатай, тодорхой үе шаттай боловсруулж хэрэгжүүлэх шаардлага байна.

Гэр бүлийн хүчирхийллээр давтан орж ирсэн хүмүүст зориулсан сургалтын тусгай хөтөлбөр байхгүй. Анх орж ирснээс ялгаа огт байхгүй, яг адилхан хөтөлбөрөөр явагддаг. Дахиад л нөгөө сургалтад суухаар би өмнө нь суучихсан гэх байдлаар идэвхтгүй ханддаг, ямар ч үр дүнгүй болдог.

*Фокус бүлгийн ярилцлагаас*

---

34 Хавсралт 1-ээс харна уу.



Баривчлагдсан хүмүүс болон бусад сургалтад хамрагдахаар заасан хүмүүст сургалтад суух цаг, хугацаа янз бүр байгаа тул сургалтын хөтөлбөрийг 3 үе шаттай ч юм уу хийвэл зүгээр. Жишээ нь: 7 хоногтой орж ирсэн хүмүүс эхний 3 хичээлд орлоо гэхэд дутуу хагас хугас юм сонсоод л гарч байна. 30 хоногоор баривчлагдсан хүмүүс заримдаа нэг сургалтад 2-3 удаа суух ч юм уу залхаад гарч байна. Тусад нь орох боломжгүй учир тэр хүмүүсийг ихэнхдээ нэг дор бүгдийг нь хамруулан оруулж байгаа.

*Фокус бүлгийн ярилцлагаас*


Зарим газарт сургалтын батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрт заагдаагүй сэдвүүдийг оруулж байгаа нь судалгаанд дурдагдаж буй шашны тухай видео бичлэгийг ойлгоогүй, намын холбогдолтой хичээл ордог, Есүсийн сургалтыг ойлгоогүй гэх хариултуудаас харагдаж байлаа.

#### *Сургалтын үнэлгээ*

Сургалтын эхэнд оролцогчдод нөхцөл байдлын үнэлгээг, хөтөлбөр дуусмагц зан үйлийг өөрчлөх хосолмол онолын загварыг ашиглан зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг оновчтой тодорхойлж төгсгөлийн үнэлгээг хийж байх зохицуулалттай<sup>35</sup>.

Сургагч багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас дүгнэхэд сургалтын үнэлгээ хийх аргачлал байхгүйгээс дийлэнх нь үнэлгээ хийдэггүй байна.

*Зураг 18. Сургалтад үнэлгээ хийдэг байдал*



Сургагч багш нараас үнэлгээ хийхгүй байгаа шалтгааныг асуухад үнэлгээний арга зүй, аргачлал мэдэхгүй тул хийдэггүй гэж 50% нь хариулсан бол бусад нь үнэлгээ авах дэвтэр бал ч байхгүй, нөхцөл боломж бүрдээгүй тул үнэлгээ хийдэггүй гэж хариулжээ.

35 ХЗДХ сайдын 2017 оны А/73 дугаар тушаалын 1-р хавсралт

Сургалтын өмнөх болон дараах үнэлгээг асуумжаар авдаг. Оролцогчид нэг удаадаа 50 хүн гэх мэтээр олуулаа орж ирдэг учир хүн бүрээс үнэлгээ аваад байх боломж огт байхгүй. Ер нь өөрсдийнх нь зан харилцаанд гарч байгаа өөрчлөлт, хүнтэй харилцаж байгаа байдлаас нь өөрчлөгдөж байгаа эсэхийг хардаг.

*“Өөрчлөлтийн хөтөч” ТББ*

## **2.7. Сургалтад хяналт тавьж буй бүтэц, механизм, санхүүжилт**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг доорхи байдлаар тодорхойлсон:

Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих<sup>36</sup>, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь<sup>37</sup> гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, Шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх хугацаа, хуваарийг нарийвчлан тогтоож, энэ хуулийн Арван есдүгээр бүлэгт заасан журмын дагуу биелэлтэд нь хяналт тавина<sup>38</sup>, Шийдвэр гүйцэтгэгч заасан хугацаа, хуваарь, шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн этгээдэд албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах тухай саналыг прокурорт гаргана<sup>39</sup>.

Хорих анги, баривчлах төв, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийн дарга нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих<sup>40</sup>, сургалтын явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах<sup>41</sup>-аар холбогдох журмаар зохицуулсан. Түүнчлэн Улсын Их Хурал, Засгийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл зэрэг байгууллагаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан чиг үүргийнхээ дагуу хуулийн хэрэгжилтэд нь хяналт тавьж байгаа эсэх мэдээлэл нээлттэй бус байна.

36 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 11

37 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 12

38 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 189.1

39 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 189.9

40 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 2 хавсралтаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам” 2.2

41 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 1 хавсралтаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 5.1.8

Сургагч багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагуудаас сургалтад хяналт тавьж буй байдал нь улиралдаа нэг удаа дээд шатны байгууллагадаа тайлан хүргүүлэх, мэдээллийг шаардсан цагт нь өгөх байдлаар, нийслэл болон орон нутгийн хэмжээнд алба, тасгийн даргад тайлагнах, прокурор нь хоригдол, баривчлагдсан этгээдийн хувийн хэрэгтэй танилцах, сургалтын үйл ажиллагааны мэдээллийг өгөх хэлбэрээр явагдаж байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалттай холбоотойгоор прокурор зөвхөн улиралдаа нэг удаа тайлан авах байдлаар хяналт тавьдаг.

*Завхан аймаг*

Сургалтад Прокуророос хяналт тавьдаг. Тайлан авах нэгдсэн маягт, асуулга байхгүй. Байгууллага бүр өөрсдийнхөө хийсэн ажлыг бичдэг.

*Фокус бүлгийн ярилцлага*

### *Санхүүжилт*

Баривчлах болон хорих ял шийтгүүлсэн этгээдүүдэд сургалтыг явуулахад сургалтын орчин нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүн, сургагч багшийг сургах, мэргэшүүлэхтэй холбоотой бүхий л асуудал нь санхүүжилтээс шууд хамааралтай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “ялтны гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлаас бусад захиргааны, зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ”<sup>42</sup> гэж заасан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын төсөв, төрийн болон төрийн бус байгууллагын санхүүжилт, байгууллагын дотоод орлого гэсэн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр<sup>43</sup> заасан.

Хүчирхийлэл үйлдэгч нарын зан үйлд нөлөөлөх албадан сургалтын зохион байгуулалтын хүрээнд<sup>44</sup> Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба нь Хууль зүй, дотоод хэргийн

42 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 299.5

43 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 1 хавсралт “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 10.1

44 Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2019 оны 12-р сарын 11-ны 7/5483 тоотгоор ирүүлсэн мэдээлэл

сайдын багцын гэмт хэргээс урьчилан сэргийлэх зардлаас 2019 онд 52,5 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвд баривчлагдсан хүмүүст зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулахад шаардлагатай гарын авлага, тараах материаллыг бэлтгэн, сургалт зохион байгуулах ажиллагаанд зарцуулжээ. Сургалт явуулах зөвлөх үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, “Өөрчлөлтийн хөтөч донтолтоос эдгээх сургалт, зөвлөгөөний институт” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна.

Бусад байгууллагуудад албадан сургалт явуулах санхүүжилт хомс, дийлэнх нь санхүүжилтгүй байна.

Манай анги албадан сургалт явуулахад зориулан жилд 100,000 төгрөг төсөвлөсөн. Бичиг хэргийн материалдаа явчихдаг, хүрэлцдэггүй.

*(ШШГЕГ-ын Хорих 421-р анги)*

- Зан үйлд нөлөөлөх сургалтыг сард нэг удаа явуулдаг. Сургалтад зориулсан санхүүжилт байхгүй учир сургалтыг тогтсон төрийн бус байгууллагатай гэрээлэн гүйцэтгэдэггүй.

*Баянхонгор аймаг*

- ШШГГазартай гэрээлэн ажилладаг, сургалтад суух хүмүүсээс бичиг хэрэг гэж жаахан зардал авч сургалтаа явуулдаг.

*Хөвсгөл аймаг*

- Цагдаагийн байгууллага болон ШШГЕГ ямарч төсөвгүй

*Өмнөговь аймаг*

- Санхүүжилт хэмжээ, тогтвортой байдал огт байхгүй.

*Дархан*

*уул аймаг*

- Санхүүжилт байхгүй. Албаны хэрэгцээнд цаас л авдаг. 5-н мэргэжилтэн дундаа 3 компьютертэй.

*Хорих 407-р анги*

- Байгууллагад төсөв байхгүй. Зөвхөн бичгийн цаас олгодог.

*ШШГЕГ-ын Баривчлах төв*

- Манайх төсөвгүй учраас мэргэшсэн багш авч чадахгүй байна.

*Баян-Өлгий аймаг*

Иймд Засгийн газраас хуульд заагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны шаардлагатай зардлыг улсын төсөвт тусгаж УИХ-аар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

## 2.8. Салбар дундын хамтын ажиллагаа, мэдээллийн сангийн нэгдсэн бүртгэл

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах хуулийн хэрэгжилтийг хангахын тулд төрийн болон төрийн бус байгууллага хамтарч ажиллах, сургалтад оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах, сургалтыг төрийн бус байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлж болох талаар хууль, журамд холбогдох зохицуулалт тусчээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, чиглэл өгөх, хяналт тавих<sup>45</sup> чиг үүргийг хуулиар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүлээлгэжээ.

Байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог судлахад ШШГ байгууллага болон цагдаагийн байгууллага нь албадан сургалтыг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа нь нийтлэг байна.

### Жишээ

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв нь “Эрчүүд, Гэр бүл хөгжлийн нийгэмлэг”, “Ивээлийн үйлчлэл”, “Help International”, “Өөрчлөлтийн хөтөч, донтолтоос эдгээх сургалт зөвлөгөөний институт”, “Хорихын үйлчлэлийн нэгдсэн төв” зэрэг ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулсан. Хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын сургагч багш нар 4985 баривчлагдсан этгээдэд 9970 цагийн танхимын сургалтыг зохион явуулсан<sup>46</sup>.

Мөн зан үйлд нөлөөлөх сургалтын чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагын сургалтад мэргэжилтнүүдээ хамруулан сургажээ.

Төрийн бус байгууллага нь ихэнхдээ төслийн хүрээнд сургалт хийхэд хамтарч ажилладаг, төсөл дууссан тохиолдолд үргэжлүүлэн хийдэггүй тул сургалтыг тасралтгүй явуулахад бэрхшээл үүсдэг. Зан үйлд нөлөөлөх сургалт явуулах чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага орон нутагт байдаггүй, ТББ-ын сургагч багш мэргэшээгүй

45 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 12.1.2

46 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, нэгжид зохион байгуулагдаж байгаа зан үйлд нөлөөх албадан сургалтын талаарх 2020 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн тайлангаас авч үзвэл.

байдаг зэрэг нь сургалтын үр дүнд сөргөөр нөлөөлдөг байна. Албадан сургалт дууссаны дараа хүчирхийлэл үйлдэгчийг харьяа хамтарсан багт нь хүлээлгэн өгч, хамтран ажилласан Баян-Өлгий аймгийн сайн туршлагыг цаашид авч хэрэгжүүлбэл албадан сургалтын үр дүнд илүү сайнаар нөлөөлөх боломжтой байна.

Өмнө жил баривчлах байрнаас гарч байгаа хүнээ хамтарсан багт хүлээлгэн өгч энэ хүн ийм сургалтад хамрагдсан, цаашид энэ тал дээр нь анхаарч ажиллаарай гэсний дагуу хамтарсан баг хяналтаа тавиад ажилладаг байсан бол энэ жил тэр байдал алдагдаад хамтарч ажиллаж чадахгүй байгаа.

*Баян-Өлгий аймаг*

Ихэнхдээ хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах хугацаа дуусахаар ар гэрээс нь баривчлах байрны төлбөр төлөх гэж очих буюу, эсхүл төлбөрөө шилжүүлсэн бол өөрөө гараад явчихдаг учир хамтарсан багтай холбож өгдөггүй байна. Харин хорих ангиас суллагдсан тохиолдолд Прокурорын хяналтад өгдөг ажээ.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь архины албадан эмчилгээтэй холбогддоггүй, зөвхөн архины хамаарлаас гарах сургалтын хөтөлбөрөөр хязгаарлагдаж байна.

Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх хүрээнд хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаархи бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах үүргийг хүлээн<sup>47</sup> хэмээн заасан боловч мэдээллийн сангийн мэдээллийг нэгдсэн санд бүртгэдэггүй, мэдээлэл нээлттэй бус, мэдээлэл өгөх нэгжүүд нь ямар маягт, асуулгаар мэдээгээ өгөх нь тодорхойгүй байна. Энэхүү тодорхойгүй байдлаас үүдэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдсан эсэх талаарх мэдээлэл нь улсын хэмжээнд нэгтгэгдэхгүй байна.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн мэдээллийн санд бүртгэдэггүй. Тийм асуулга байхгүй. Тийм сан ч хаана байх ёстойг мэдэхгүй. Зөвхөн хувийн хэрэгт нь бүртгэл мэдээлэл нь үлддэг.

*Фокус бүлгийн ярилцлагаас*

47 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) 25.1 /манайхын нийтлэг барьдаг ишлэлийн стандарт/

## **2.9. Албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэрийн хэрэгжилт**

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасан албадан эмчилгээ, албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах зохицуулалттай.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаалын 1 хавсралтаар баталсан Зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийн 9.1-т “баривчлагдсан оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтыг шүүхээс тогтоосон албадан сургалтын цагтай уялдуулан харилцан адилгүй тогтоож болно” гэж заасан.

Хуулиар албадан сургалтад хамруулах цагийн дээд болон доод хязгаарыг тогтоож өгсөн боловч ял, шийтгэл эдлэх хугацааг сургалтад хамрагдах цагтай хэрхэн уялдуулан тогтоох талаар нарийвчилсан зохицуулалт байдаггүйгээс шүүхүүд албадан сургалтад хамруулах цагийг өөр өөрийнхөөрөө тогтоож байна.

Шүүхээс хүчирхийлэл үйлдэгчид албадлагын арга хэмжээ авахдаа албадан сургалтад хамрагдах цагийг баривчлагдсан хугацаатай нь уялдаагүйгээр хэт урт, эсхүл хэт богино тогтоож байгаа нь оролцогч сургалтаа дуусгаж амжаагүй байхад баривчлагдах хугацаа нь дуусах зэргээр сургалтын үр дүнд муугаар нөлөөлж байна.

Шүүхээс оноож байгаа албадан сургалтын цаг дээр нилээд асуудал байна. Журамд 56 хүртэлх цаг гээд заагаад өгчихсөн байхад шүүх 10 цагийн сургалтад хамруулахаар шийдэж байгаа нь учир дутагдалтай байна. 10 цагийн сургалтад сууснаар тухайн хүний хандлагад өөрчлөлт гарахгүй шүү дээ.

*Фокус бүлгийн ярилцлага, Дархан Уул аймаг*

Түүнчлэн 2 өөр төрлийн зөрчил гаргасан этгээдэд сургалтын нэг хугацаа тавих, ижил хугацаатай баривчлагдах шийтгэлд сургалтын өөр өөр хугацаа тогтоох, ижил зөрчилд албадан сургалтад хамруулахдаа шийдвэрийн биелэлтийг өөр өөр байгууллагуудад даалгах зэрэг ойлгомжгүй асуудлууд гарч байна. Сургалтыг календарьчилсан төлөвлөгөөний дагуу явуулахад оролцогч сургалтын дундаас сургалтад хамрагдах явдал гарч байна.

Зөрчлийн тухай хуульд албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна<sup>48</sup> гэж заасан атал хөтөлбөрт сургалтын нийт цаг 23-56 цаг байна<sup>49</sup> гэж заасныг хуульд нийцүүлэн нэг мөр болгох шаардлагатай байна.

Ажлын ачааллаас болоод сургалт явуулах цагаа гүйцээж амждаггүй. Хичнээн хичээж шахсан ч оролцогч шүүхээс оногдуулсан суух ёстой сургалтын цагаа гүйцээхгүйгээр баривчлах хугацаа нь дуусаад гарчихдаг. Энэ тохиолдолд суугаагүй үлдсэн сургалтыг гадуур үргэлжлүүлэн ордог байгууллага маш их хэрэгцээтэй байна. Тийш нь холбож өгөөд тэр байгууллагад бас прокурор хяналт тавьдаг бол зүгээр санагддаг.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл*

Сургалт шүүхийн тогтоол шийдвэрт заасан цагтаа багтахгүй гарах тохиолдол их байдаг. Жишээ нь, 14 хоногтой орж ирж байгаа хүнд 50 цаг гээд заачихсан нь яагаад ч багтдаггүй. Сургалтыг нэг удаа 1 цаг 30 минутаас 2 цагаар ордог. Тэгэхээр бодитой шийдвэр гаргахад шүүхийн байгууллагад нөлөөлөх шаардлагатай байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс*

Шүүхээс 7 хоног баривчлаад, 50 цагийн сургалтад суулга гэдэг. 7 хоногийн хугацаанд яагаад ч 50 цагийн сургалтад хамруулах боломжгүй. Сургалтаа гүйцээлгүй гараад явж байгаа хүмүүс олон байна.

*Сургагч багш нараас авсан мэдээллийн нэгтгэлээс*

Энэ нь практикт хүндрэл бэрхшээл учруулах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхгүй байх, сургалтын үйл ажиллагаанд зарим талаараа хүнийг эрхийг хөндөх нөхцөл бий болгох талтай.

## **2.10. Албадан сургалтад оролцогч, хохирогчдын сэтгэл ханамж**

Албадан сургалтад оролцогч, хохирогчдын сэтгэл ханамжийн байдлыг судлахын тулд нөхөр, хамтран амьдрагч нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас Зөрчлийн тухай хуулиар баривчлагдсан, эрүүгийн хариуцлага хүлээсэн хэргийн 25 хохирогч, дээрх гэмт хэрэг, зөрчлийн улмаас ял шийтгэл эдэлж, албадан сургалтад хамрагдсан 47 хүчирхийлэл үйлдэгчээс урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу асуулгын арга ашиглан судалгаа авч, ганцаарчилсан ярилцлага хийлээ.


Хүйсийн хувьд авч үзвэл судалгаанд хамрагдсан 47 баривчлагдагсдыг 44 нь эрэгтэй, 3 нь эмэгтэй хүн байна. Тэдгээрийн дийлэнх буюу 40% нь 30-49 насны хүмүүс эзэлж байна. Боловсролын түвшингээр нь авч



үзвэл бүрэн бусаас бүрэн дунд боловсролтой хүмүүс 68% эзэлж байна. Сургалтад хамрагдагсдаас 3 нь огт боловсролгүй, бичиг үсэг мэдэхгүй хүн байв.




Зураг 6. Хүчирхийлэл үйлдэгчийн нас



Зураг 7. Хүчирхийлэл үйлдэгчийн боловсролын түвшин

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан 47 хүний 24 хүн нь баривчлагдсан байх хугацаандаа 5-аас дээш удаа, 8 хүн нь 3-5 удаа, 15 хүн нь 1-2 удаа сургалтад хамрагджээ.



Хүснэгт 8. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан тоо

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этггээдэд явуулах албадан сургалт нь гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлийг бий болгох зорилготой тул сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь зорилгод чиглэсэн байх ёстой.

Судалгааны дүнгээс харвал зан үйлд нөлөөлөх албадан сургалтын дийлэнх агуулга нь хүчирхийлэл үйлдэгчид хууль таниулж мэдээлэл өгөх, дахин гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талыг анхаарчээ. Харин гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, өөрийгөө ойлгуулж илэрхийлэх, гэр бүлийнхэнтэйгээ эв зүйгээр ойлголцох, харилцан ярилцах зэрэг харилцааны чадвар суулгах, өөрийн зан үйлд дүгнэлт хийж засах арга зүйн асуудлыг бага хөндөж байгаа нь хүчирхийллийн үйлдлээ дахин давтахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Хүчирхийлэл үйлдэгч дахин хүчирхийлэл үйлдэж албадан сургалтад хамрагдсан 3 удаагийн тохиолдол хохирогчдоос өгсөн мэдээлэлд бүртгэгдсэнээр батлагдаж байна.

Хорих анги, баривчлах байруудад зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах нь зөв гэж сургалтад оролцогсод 100% хүлээн зөвшөөрсөн нь сургалтын хэрэгцээ байгааг харуулж байна.


Хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулсан эсэх талаар хохирогчид хэн ч мэдээлэл өгдөггүй, зөвхөн хүчирхийлэл үйлдэгчээс өөрөөс нь сонссон байна.

Оролцогчдын дийлэнх нь сургалтыг “ойлгомжтой” гэж тодорхойлсон. Хамгийн сайн ойлгож мэдсэн зүйлээ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” гэж үзсэн бол ойлгомжгүй байсан сэдвүүдийг Есүсийн сургалт, шашны номлол, намын холбогдолтой яриа хэмээн тодорхойлжээ.



Зураг 16. Сургалтаас ойлгомжгүй байсан сэдэв

Судалгаанд оролцсон, сургалтад хамрагдсан 47 хүнээс авсан судалгаагаар сургалтыг сайн, хангалттай, дунд, боломжийн хэмжээнд гэж ихэнх нь үнэлсэн байна.



Зураг 17. Сургалтад өгсөн үнэлгээ (Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдагсад)

Хохирогч нартай хийсэн ганцаарчилсан ярилцлага болон урьдчилан бэлтгэсэн асуулгын хүрээнд авсан судалгааны дүнгээс үзвэл албадан сургалтад хамрагдсаны дараа хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд эерэг өөрчлөлт гарсан гэж судалгаанд хамрагдсан 25 хохирогчийн 10 нь тодорхойлсон бол “өөрчлөгдөөгүй, мэдэхгүй” гэж 15 нь хариулжээ. Сургалтад хамрагдсанаас хойш хүчирхийлэл үйлдэгчийн уурлаж бухимдах, өширхөх, заналхийлэх, сүрдүүлэх буураагүй, харин ч илүү нэмэгдсэн гэж 16 хохирогч, гэр бүлийн харилцаанд ямар ч өөрчлөлт гараагүй, сөрөг өөрчлөлт гарсан гэж 18 хүн хариулсан нь сургалтын үр дүн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд эерэгээр нөлөөлж чадахгүй байгааг харуулж байна.

Албадан сургалтыг явал үр дүнтэй, чанартай явуулах вэ? гэсэн асуултад оролцогчид хариулахдаа сургалтын байр, танхимын зохион байгуулалтыг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, оролцогчдыг идэвхжүүлэх, багш нарын мэдлэг, заах ур чадварыг сайжруулах, сургалтыг тогтмол давтамжтай, урт хугацаанд явуулж байх, сургалтад оролцогчдын тоог цөөрүүлэх, эхнэр, гэр бүлийн гишүүдэд харилцааны талаарх сургалт явуулах гэж хариулжээ.

Харин хохирогч нарын хувьд сургалтыг архины эмчилгээтэй хослуулж явуулах, баривчилгаанаас гарсны дараа ч сургалтыг үргэлжлүүлэн явуулж байх, сургалтад хамрагдсаны дараа амьдрал дээр өөрчлөгдөж буй эсэхэд нь хяналт тавьж байх, ажлынх нь хажуугаар сургалтад суулгаж байх, гэр бүлтэй нь хамт сургалтад хамруулах нь илүү үр дүнтэй гэж үзжээ.

Сургалтыг үр дүнтэй явуулахын тулд тусгай нэг хүнд хариуцуулаад үүрэгжүүлж, ажлын байрны тодорхойлолтод зааж өгөх, сургалт орж байгаа байгууллагууд хоорондоо уялдаатай төлөвлөгөө гаргаж, хуваарийг

мөрдөж ажиллах, сургалтын хөтөлбөрийг маш ойлгомжтой нэгдсэн байдлаар, ийм хэрэг зөрчилд шийтгүүлсэн этгээд, ийм хугацаатай орж ирвэл энэ хөтөлбөрөөр явуулж дуусгана гэсэн байдлаар батлах, сургагч багш нараа бэлтгэх нь үр дүнтэй гэж сургагч багш нар тодорхойлсон байна.

## ДУГНЭЛТ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хариуцлагын гадна үлддэг байдлыг халж, хариуцлага хүлээлгэж зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж байгаа нь сайшаалтай ч албадан сургалт зохих журмын дагуу явагдахгүй, үр дүн төдийлөн мэдэгдэхгүй, зөрчил гаргагч давтан зөрчил үйлдэх, гэмт хэрэгт холбогдох явдал буурахгүй байгаад анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх, сургалт явуулах алба хаагчдыг мэргэшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн давтан, мэргэшүүлэх, үргэжилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж системтэй хамруулах ажлын зохион байгуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Мониторингод хамрагдсан ихэнх аймгуудын хорих анги, баривчлах байруудад зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах орчин нөхцөл бүрдээгүй байгаа нь сургалт зохион байгуулахад ихээхэн бэрхшээл үүсгэж байна. Орон нутгийн Цагдаагийн газрын дэргэдэх баривчлах байруудын ихэнх нь сургалтын өрөө танхимгүй байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хариуцан зохион байгуулах бэлтгэгдсэн сургагч багш цөөн, боловсон хүчин, хүний нөөц дутмаг, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа мэргэжилтэн хомс байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах сургагч багш нарыг мэргэшүүлэх, тогтмол сургалтад хамруулах ажил хангалтгүй байна. Энэ талаарх сургалтын нэгдсэн хөтөлбөр байхгүй, жил бүр тогтмол сургалтад хамруулах ажлыг нэгтгэн хариуцсан байгууллага байхгүй байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж байгаа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод албадан сургалт явуулах чиг үүрэг тусгагдаагүй байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахад ашиглах гарын авлага, арга зүйн материал, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалтгүй байна. Зарим газарт сургалтын гарын авлага огт байхгүй байгаа нь сургалтыг үр дүнтэй явуулахад сөргөөр нөлөөлөх үзүүлэлт юм.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр нь үр дүнд суурилсан сургалтын нэгдсэн бодлогын баримт бичгийн түвшинд боловсруулагдаж гарсан байх шаардлагыг хангахгүй байна. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, сэдэвчилсэн болон календарьчилсан төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын материал болон гарын авлага, хэрэглэгдэхүүн, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин зэрэг хамаарал бүхий бүтцийг алдагдуулахгүйгээр тэдгээрийн нарийн уялдаа холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичгийн түвшинд боловсруулах хэрэгтэй байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай байна. Гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэж баривчлагдсан этгээдэд өмнө нь явуулсан хөтөлбөрөөр сургалтыг явуулж байгаа нь үр дүнгүй байна.

Сургалтад оролцогчийн үйлдсэн зөрчил, гэмт хэргийн шинж чанар, хор уршгаас хамаарч сургалтын зорилго, хүлээгдэх үр дүн, сургалтын хөтөлбөр өөр өөр хувилбартай байх шаардлагатай байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахдаа шүүхээс заасан хугацааг харгалзахгүй байх, шүүхээс заасан хугацаанд багтааж сургалтын агуулгыг бүрэн өгч чадахгүй байх зэрэг бэрхшээл тулгарч байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын эхний болон явцын, эцсийн үнэлгээ хийх нэгдсэн аргачлал байхгүйгээс сургалтын үр дүнд үнэлгээ хийгдэхгүй байна.

Сургалтад тавих хяналтыг хэн, хэрхэн хэрэгжүүлж байгаа нь тодорхой бус байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүн, чанарын үзүүлэлтэд илүү анхаарч ач холбогдол өгөх шаардлагатай байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хэрэгжүүлэх санхүүжилт дутмаг, хүрэлцээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг хангах буюу сургалтад зайлшгүй шаардагдах зардал, төсвийг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулах, хяналт тавих, мэдээлэл солилцох чиглэлээр салбар дундын хамтын ажиллагаа

хангалтгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг албадан сургалтад хамруулах хуулийн хэрэгжилтийг хангахын тулд төрийн болон төрийн бус байгууллага хамтрах, тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар сургалтыг зохион байгуулна гэж заасан ч орон нутагт магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын хүртээмж хангалтгүй байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаарх мэдээлэл хүчирхийлэл үйлдэгчийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэхгүй байна. Албадан сургалтад хамрагдаж байгаа оролцогчид ямар гэмт хэрэг, зөрчил үйлдсэний улмаас, хэдий хугацаагаар зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан, шүүхээс тогтоосон сургалтын цагаа гүйцээж чадсан эсэх талаарх нэгдсэн тайлан мэдээг төрийн аль ч байгууллага гаргаагүй байна.

Улсын хэмжээнд уг асуудлаарх мэдээллийн нэгдсэн сүлжээ хангалттай бүрдэж чадаагүй байгаа нь мэдээлэл, тайлангийн агуулга, үзүүлэлт нэг мөр болоогүйг харуулж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлэх тухай болон мэдээлэл солилцох журамд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44.4-т заасантай холбогдсон ямар агуулга бүхий мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх асуудал тодорхой бус байна.

Сургалтын үр дүн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд эерэгээр нөлөөлөх зорилгод хүрч чадахгүй, хохирогчийн аюулгүй байдлыг хангахад төдийлөн нөлөөлж чадахгүй байгаа нь сургалтад хамрагдсанаас хойш хүчирхийлэл үйлдэгчийн уурлаж бухимдах, заналхийлж сүрдүүлэх явдал буураагүй, харин ч илүү нэмэгдсэн, гэр бүлийн харилцаанд ямар ч өөрчлөлт гараагүй, сөрөг өөрчлөлт гарсан гэж хохирогчдын дийлэнх нь тодорхойлсноос харагдаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 4.5-д “албадан сургалт 10-50 цагийн хугацаатай байна” гэж заасантай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”-ийн 9.2-т “Сургалт тус бүрийн үргэлжлэх хугацаа, сургалтын нийт цаг 23-56 цаг байна” гэсэн заалт зөрчилдөж байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн

байгууллагатай хамтран боловсруулах, нэгдсэн хөтөлбөрт шилжүүлэх, сургалтыг төрийн бус байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлж болохоор хууль, журамд заасан ч энэ чиглэлээр мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хандаж бодитой ажлыг зохион байгуулж буй төрийн бус байгууллагууд болон мэргэжилтэн, алба хаагчдад дэмжлэг үзүүлэх, ажил дүгнэх нэг үзүүлэлтэд нь тусгаж үнэлэх, урамшуулал, нэмэлт цалин хөлс олгох гэх мэт хөшүүрэг байхгүй байна.

## **ЗӨВЛӨМЖ**

Үнэлгээний дүгнэлтэд үндэслэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

### **УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ**

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах” тухай, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасныг үндэслэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ерөнхий үйл ажиллагаанд шаардлагатай зардлын тооцооллын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;
2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн албадан сургалттай холбоотой хуулийн зохицуулалтуудыг нэг мөр болгох, агуулгын хийдлийг арилгах, хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.

### **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД**

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9.1.3, 10.1.2-т заасан төсөвт тусгах гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тооцох үзүүлэлтийг нарийвчлан гаргах замаар мөн хуулийн 44 дүгээр зүйлд заасан зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахтай холбогдсон зардлыг тусгайлан тооцоолж санхүүжилтийг шийдвэрлүүлж байх;
2. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл



хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам /2017 оны А/25 тоот тушаал/-д гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйл заалттай холбоотой мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхэд шаардлагатай статистик мэдээлэл, тоо бүртгэл, тайлангийн агуулгыг тодорхой болгон тусгах, холбогдох байгууллагаас ирүүлэх мэдээ, судалгааны маягыг нэгдсэн журмаар баталж удирдлага зохион байгуулалтаар хангах, мэдээллийн санг хариуцсан байгууллагын чиг үүргийг тодорхой болгох;

3. Зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийн минимум стандартыг боловсруулан, батлах;
4. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын нэгдсэн хөтөлбөрийг батлах, ингэхдээ сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, сургалт хоорондын уялдаа холбоог хангах, сургалтын хөтөлбөрийг үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийнх нь шинж байдал, анх ял шийтгэл эдэлж байгаа болон давтан ял шийтгэл эдэлж байгаа оролцогчдод ялгаатай байхаар боловсруулж мөрдүүлэх;
5. ХЗДХ-ын сайдын А/73 тушаалаар батлагдсан хөтөлбөр, журамд Зөрчлийн тухай хуультай нийцүүлсэн өөрчлөлт оруулах;
6. Холбогдох байгууллагуудаас гаргаж буй сургалтын хөтөлбөр, журам нь хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журамтай нийцэж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах;
7. Сургагч багш нарыг тусгайлан бэлтгэх, нэгдсэн хөтөлбөр, гарын авлага, тараах материал, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах;
8. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан этгээдийн талаарх мэдээллийг холбогдох мэдээллийн нэгдсэн санд бүрэн оруулахад анхаарах;
9. Сургалтыг бичиг, үсэг мэдэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ялангуяа хэл яриа, сонсголын бэрхшээлтэй), үндэсний цөөнхийн хэрэгцээнд нийцсэн арга, хэлбэрээр зохион байгуулах ажилд мэргэшсэн төрийн бус байгууллага, багш сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчийг татан оролцуулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор урамшуулал дэмжлэг механизмыг бүрдүүлэх;
10. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж байгаа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод албадан сургалт явуулах чиг үүргийг тусгуулах;
11. Баривчлах төвийн үйл ажиллагаа цагдаагийн байгууллагаас ШШГБ-ын харьяанд шилжихтэй холбогдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх

- газар, хэлтэст сургалт хариуцсан ажилтны орон тоог нэмэгдүүлэх;
12. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын эхний болон явцын, эцсийн үнэлгээ хийх нэгдсэн аргачлалыг боловсруулж мөрдүүлэх.

## **УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД**

1. Шүүхээс албадан сургалтын цагийг шийтгэлийн хоногт багтахуйц хэмжээнд тооцож тогтоох, шийтгэх тогтоолд зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээг тодорхой тусгах, нэг мөр хэрэглэх, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах.

## **УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАРТ**

1. Прокурорын тухай хуульд заагдсан бүрэн эрхийн хүрээнд албадан сургалттай холбоотой шүүхийн шийдвэр зохих ёсоор хэрэгжиж байгааг болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан албадан сургалтын хөтөлбөр, журмын дагуу, хуулиар тогтоосон болон шүүхийн шийдвэрт тусгагдсан хоног хугацаанд, сургалтын агуулгын хүрээнд сургалтыг явуулж байгаа эсэх, сургалтыг зорилтот бүлэгт зохион байгуулсан эсэхэд хяналт тавьж, зохих шаардлагыг тавьж ажиллах.

## **МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛД**

1. ХЗДХ-ын сайдын 2017 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан “Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмын хоёрдугаар хавсралтын 1.3-т заасан гэр бүлийн хүчирхийллийн талаарх журамд заасан мэдээллийг нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргах, тодорхой чиглэл, даалгавар өгөх, үр дүнг танилцуулах арга хэмжээг авч хэвшүүлэх;
2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтыг хөгжүүлэхэд анхаарч гадаад, дотоодын сайн туршлагыг нэвтрүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах хөтөлбөр хэрэгжүүлэх;
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9.1.3, 10.1.2-т заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тооцох үзүүлэлтийн хүрээнд мөн хуулийн 44 дүгээр зүйлийг үндэслэн зан үйлд нөлөөлөх, албадан сургалтын үйл ажиллагаатай холбогдсон зардал, төсвийн асуудлыг шийдвэрлэж хэрэгжүүлэх;

4. Хуулийн хэрэгжилт, практикт үүсч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх асуудалтай уялдуулж Эрүүгийн хуульд сургалтын үргэлжлэх дээд доод цагийг тогтоох, Эрүүгийн хуулийн албадлагын арга хэмжээг хэрэглэх талаарх зохицуулалтыг Зөрчлийн хуульд заасан агуулгатай уялдуулж албадан сургалтыг боловсронгуй болгох;
5. Албадан сургалтын сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, заах арга зүйн мэдлэг ур чадвар олгох, мэргэшүүлэх, давтан сургах, сургалтад үнэлгээ хийх арга аргачлал боловсруулах ажилд Дотоод хэргийн их сургуулийг татан оролцуулж хамтран ажиллах.

### **ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ**

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын төлөвлөгөөг анх удаа болон давтан зөрчил, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялгамжтай байдлаар баталж, сургалтыг батлагдсан агуулга, арга зүйн дагуу тодорхой үе шаттайгаар зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, сургагч багш нарт хүртээмжтэй болгох, зайн сургалтыг зохион байгуулах нөхцөл боломжийг судалж, хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах;
2. Албадан сургалт явуулах чиг үүрэгт хамаарах төрийн алба хаагч буюу үүрэг хүлээсэн сэтгэл зүйч, эмч, сургалт хариуцсан мэргэжилтэн зэрэг албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, сургалт явуулах багш нарыг нэгдсэн сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллаж байгаа сургагч багш нарт урамшуулал, дэмжлэг үзүүлэх, материаллаг баазаар хангах, сургалт хариуцсан ажилтны орон тоог нэмэгдүүлэх;
3. Албадан сургалтад оролцсон хүмүүсийн талаарх мэдээллийг хүчирхийлэл үйлдэгчийн мэдээллийн санд бүртгэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах.

### **ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ**

1. Албадан сургалт явуулах чиг үүрэгт хамаарах төрийн албан хаагч буюу сургалт хариуцсан сэтгэл зүйч, эмч, мэргэжилтэн зэрэг алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод сургалт явуулахтай холбоотой чиг үүргийг тодорхой тусгах, сургалт явуулах багш нарыг нэгдсэн сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллаж байгаа сургагч багш нарт урамшуулал, дэмжлэг үзүүлэх, тогтвортой

- ажиллуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, материаллаг баазаар хангах;
2. Зорилтот бүлэгт чиглэсэн зан үйлээ засах, зан үйлд нөлөөлөх сургалтын төлөвлөгөөг ялгамжтай байдлаар боловсруулж дагаж мөрдөх;
  3. Албадан сургалтад оролцсон хүмүүсийн талаарх мэдээллийг хүчирхийлэл үйлдэгчийн мэдээллийн программд бүртгэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;
  4. Сургагч багш нарыг нэгдсэн журмаар бэлтгэх, сургагч багш бэлтгэх сургалтын агуулгад заах арга зүйн болон боловсрол судлалын ерөнхий мэдээлэл олгох асуудлыг тусгахад анхаарч сургалт хариуцсан ажилтны орон тоог нэмэгдүүлэх.

### **ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨВД**

1. Шүүн таслах ажилагааны тайланд үүрэг хүлээлгэж, эрх хязгаарлах албадлагын төрөл, зүйлчлэл, хамрагдсан хүн, сургалтын цаг, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, тоон үзүүлэлтийг тодорхой болгож судалгааг нэгтгэн гаргах.

### Хүснэгт 1. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

	Аль шүүх	Огноо	Хуулийн үндэслэл	Хэнийг	Ямар хугацаагаар	Гүйцэтгэх этгээд
1	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн анхан шатны шүүх Шийтгэвэр	2019-11-25 Д-167	Зөрчлийн тухай хуулийн 5.4 –р зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 дэх зааснаар	Б.М-г	Албадан сургалтад 14 /арван дөрөв/ цагийн сургалтад хамруулж 10 /арав/ хоног баривчлах	Завхан аймаг дахь Цагдаагийн газарт даалгасан
2	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн анхан шатны шүүх Шийтгэвэр	2019-11-18 Д-164	Зөрчлийн тухай хуулийн 5.4 –р зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 дэх зааснаар	Т.Д-г	Албадан сургалтад 10 /арав/ цагийн сургалтад хамруулж 10 /арав/ хоног баривчлах	Завхан аймаг дахь Цагдаагийн газарт даалгасан
3	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх Шийтгэвэр	2019-10-11	Зөрчлийн тухай хуулийн 5.4 –р зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 дэх зааснаар	Ц.А-г	Албадан сургалтад 40/ дөч/ цагийн сургалтад хамруулж 30/ гуч/ хоног баривчлах	Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд даалгасан
4	Баянзүрх дүүргийн Эрүүгийн анхан шатны шүүхийн шийтгэвэр	2019-01-15 Д-329	Зөрчлийн тухай хуулийн 5.4 –р зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 , 4.2. зааснаар	Ю.Д	Албадан сургалтад 15 цагийн сургалтад хамруулж, 10 хоног баривчлах	Баянзүрх дүүргийн эрүүгийн анхан шатны шүүхийн д-1423 шийтгэх тогтоолын тодорхойлох хэсгээс авсан /
5	Баянзүрх дүүргийн Эрүүгийн анхан шатны шүүхийн шийтгэвэр	2019-03-19 Д-576	Зөрчлийн тухай хуулийн 5.4 –р зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 зааснаар	Ю.Д /Давтан/	Албадан сургалтад 30 цагийн сургалтад хамруулж, 30 хоног баривчлах	даалгасан байгууллага нь дурьдаагүй байсан болно/

## Хүснэгт 2.

### Урьдчилан сэргийлэх, мэдээлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан:

№	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Чиг үүрэг
1	Бүх шатны боловсролын байгууллагын багш, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан	29.2	Хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, ажилтан нь хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүрэгтэй.
2	Нийгмийн ажилтан	32.1	Нийгмийн ажилтан нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй байдлыг, хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагаварт үнэлгээ хийнэ.
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	45.1.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүргийг хуулиар хүлээсэн төрийн захиргааны төв байгууллагын болон аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн ажлын тайланг хагас, бүтэн жилээр хэлэлцэн чиглэл өгөх, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтны илтгэл, мэдээллийг сонсож, хамтын ажиллагааг зохицуулах;
4	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	11.1 11.1.1 11.1.2 111.1.4	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг энэ хууль болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу зохион байгуулах; - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон хүчирхийллээс урьдчилан

			<p>сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;</p> <p>- Гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталж, хэрэгжилтэд хяналт тавих;</p>
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	12.1 12.1.1 12.1.3 12.1.4	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналыг боловсруулах;</p> <p>-Холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p>
6	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	15.1.3	Нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах, мэдээллийн сан бүрдүүлэх;
7	Прокурорын байгууллага	17.1	Прокурорын байгууллага гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг нарийвчлан судалж дүгнэлт гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавина.

8	Бүх шатны засаг дарга	19.1 19.1.1	Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ - Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
9	Хамтарсан баг	20.1 20.2.1 20.2.2 20.2.6	Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална. Хамтарсан баг дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: - Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах; - Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
			-Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.
10	Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	21.1.1	21.1. Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: - Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх;



**Хүснэгт 3. Сургалт зохион байгуулах, явуулах  
чиг үүрэг бүхий байгууллага**

№	Байгууллага	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Чиг үүрэг
1	Магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага	44.2.	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно.
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллага	44.4	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна.
3	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	11.1.5	Хууль сахиулагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандартад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэглэх ур чадвар эзэмшүүлэх агуулгыг тусгах;
4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	12.1.5	Хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлан мөрдүүлж байгаа эсэх, холбогдох дүрэм, журмын хэрэгжилт болон ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавих хяналтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
5	Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	13.1.2 13.1.4	- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах хөтөлбөр болон сургалт зохион байгуулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих; - Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үйлчилгээ

5			үзүүлэх ажилтныг бэлтгэх, арга зүйгээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;
6	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллага	Хүүхэд хамгааллын тухай хууль 18.2.6	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа 18.2.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулна.

#### **Хүснэгт 4. Хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага**

№	Байгууллага	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	Чиг үүрэг
1	Монгол Улсын Их Хурал	45.1.1	Улсын Их Хурал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаархи Засгийн газрын тайланг жил бүр хэлэлцэн, шийдвэр гаргах;
2	Засгийн газар	45.1.2	Монгол Улсын Засгийн газар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн тайланг жил бүр хэлэлцэн, чиглэл өгөх;
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	45.1.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүргийг хуулиар хүлээсэн төрийн захиргааны төв байгууллагын болон аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн ажлын тайланг хагас, бүтэн жилээр хэлэлцэн чиглэл өгөх, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтны илтгэл, мэдээллийг сонсож, хамтын ажиллагааг зохицуулах;
4	Мэргэжлийн хяналтын байгууллага	45.2.	Мэргэжлийн хяналтын байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавина.

	Шүүх	Зөрчлийн тухай хууль 4.5.1	Шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.
	Прокурор	Прокурорын тухай хууль 11.1.2, 11.1.5, 11.1.6, 12.1.6, 16.1.3, 22.1.1, 24.1.1, 24.1.2, 24.1.4, 24.1.5	<p>Прокурорын бүрэн эрх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;</li> <li>- Эрх хязгаарлах арга хэмжээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;</li> <li>- Эрх бүхий албан тушаалтан албадлагын арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэж байгаа эсэх.</li> <li>- Зөрчлийн хэрэг бүртгэлтэд хуулийн хэрэгжилтийг шалгах;</li> <li>- Хуулийн хэрэгжилтэд шалгалт, судалгаа хийх;</li> <li>-Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;</li> <li>- Хуулийн хэрэгжилттэй танилцах, шалгах, судалгаа хийх;</li> <li>- Байгууллага, албан тушаалтнаас мэдээ, судалгаа, баримт гаргуулан авах, тайлбар гаргуулах, тодорхойлолт авах;</li> <li>- Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэргэжлийн туслалцаа авч, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.</li> </ul>

**Хүснэгт 5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны  
зардал, санхүүжилт**

№	Байгууллага, албан тушаалтан	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Тайлбар
1	Монгол Улсын Их Хурал	9.1.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган батлах
2	Монгол Улсын Засгийн газар	10.1.2	Төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	12.2.1	Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгуулах саналыг тухайн шатны Засаг даргад уламжлах
4	Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	13.1.4	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх ажилтныг бэлтгэх, арга зүйгээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;
5	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	15.1.1	Нэг цэгийн үйлчилгээ, сэтгэл заслын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх
6	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	18.1.2	Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;
7	Бүх шатны засаг дарга	19.1.4 19.1.5	Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ - Харьяалах нутаг дэвсгэртээ гэр

		<p>19.1.6 19.1.7 19.1.8</p>	<p>бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>- Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>- Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;</li> <li>- Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;</li> <li>- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;</li> </ul>
--	--	-------------------------------------	--

8	Төрийн бус байгууллага	22.3	Гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагад олгох санхүүжилт, ажилтны цалин, урамшуулал нь адил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагынхаас багагүй байна.
9	Нийгмийн ажилтан	26.1.7	Хохирогчид үзүүлэх хамтарсан багийн үйлчилгээг төлөвлөх, уялдуулан зохицуулах, үйлчилгээний тайлан, мэдээнд үндэслэн дараа жилийн үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах саналыг Засаг даргад гаргах;
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 299.5	Ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлаас бусад захиргааны, зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

**Хүснэгт 6. Ажлын байрны тодорхойлолтонд тусгах, хяналт тавих үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан**

№	Байгууллага	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Чиг үүрэг
1	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	11.16	Харьяа агентлаг, байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих;
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	12.1.5	Хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлан мөрдүүлж байгаа эсэх, холбогдох дүрэм, журмын хэрэгжилт болон ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавих хяналтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

3	Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	13.1.3	Харьяа агентлаг, байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих;
4	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	14.1.3	Боловсролын байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих;
5	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	15.1.5	Эрүүл мэндийн байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих

**Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр холбогдох бусад хууль тогтоомжтой харьцуулан практикт гарч буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэх зарим арга зам**

**Хүснэгт 7.** /Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04 дугаар сарын 04-ны өдрийн А/73 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт/

№	А/73-тушаалд байгаа агуулга	Хууль хоорондын уялдаа зөрчил	Тулгарч буй бэрхшээл, асуудал	Шийдвэрлэх асуудал
1	<p>Зорилго</p> <p>3.1. Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, тэндий мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын зэрэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон</p>	<p><b>ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /2016 он/ 44 дүгээр зүйл. Зан үйлд нөлөөлөх сургалт</b></p> <p>44.1.Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байна.</p> <p>44.4.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна.</p> <p><b>ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ /2017 он/</b></p> <p>6.4.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараахь шийдвэрийг үндэслэн явуулна:</p> <p>6.4.4.албадан эмчилгээ, албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэр;</p>	<p>Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг нийтлэг байдлаар оруулсан нь гэмт хэрэг зөрчлийн төрлөөс үл хамаарч гэмт хэрэгтэн, зөрчил гаргагч бүрт хамааралтай сургалт мэт хавтгайруулан ойлгогдох нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй байна.</p> <p>Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх бус нэгэнт зөрчил гаргасан этгээдэд сургалт явагдаж буй тул дахин тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын агуулгад чиглэх ёстой.</p>	<p>Сургалтын зорилгоос сургалтын үр дүн тодорхойлогдох бөгөөд зорилго нь тодорхой зорилтод этгээдрүү чиглэсэн үр дүн нь тодорхой байхаар зохицуулах.</p> <p>Хуульд сургалтын хамрагдах ёстой зорилгот бүлгийг болон сургалтын чиглэл зорилгыг тодорхой заасан байгаа бөгөөд үүнтэй нийцүүлэн хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох.</p>



2	телевүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.	147.5. Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна.	Эрүүл мэндийн байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих	
3	9.2. Сургалт тус бүрийн үргэлжлэх хугацаа Сургалтын нийт цаг 23-56 цаг байна	Зөрчлийн тухай хууль /2017 он/ 4.5 дугаар зүйл. Албадан сургалт <ul style="list-style-type: none"> <li>3. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.</li> </ul>	- Хөтөлбөрийн цаг хуулиар тогтоосон цагаас илүү байна Энэ нь хүний эрхийн хөндөх, төсөвт хүндрэл үүсэх эрсдлийг үүсгэж байна. Хууль журмын заалт зөрчилдөх.	Хуульд нийцүүлэн дээд хугацааг 50 цаг байхаар зохицуулах.

## Хүснэгт 8.

### Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйл 44.4

44.4-Т байгаа агуулга	Хууль хоорондын уялдаа зөрчил	Тулгарч буй бэрхшээл, асуудал	Шийдвэрлэх асуудал
Зан үйлд нөлөөлөх	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ 7.3 дугаар зүйл. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ 2.2 Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах;	Зан үйлээ засах сургалт гэдэг нь сургалтын оролцогч төвтэй байна, зан зүйлд нөлөөлөх гэдэг нь сургалтыг хэрэгжүүлэгч байгууллага буюу багш төвтэй сургалт байна. Тодруулвал, Хуульд зан зүйлд нөлөөлөх, зан үйл засах гэсэн 2 өөр нэр томъёогоор тусгасан байна. Мөн зан үйлээ засах сургалтын хөтөлбөр, журам эсхүл зан үйлийг өөрчлөх сургалтын журам, хөтөлбөр гэж байх, хуулийг хэрэгжүүлэх, сургалтын зорилгыг тодорхойлоход хүндрэл үүсгэж байна.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн уг заалтыг шинэчлэн найруулах, холбогдох хуулиудын нэр томъёо, агуулгыг нэг мөр болгох, “зан үйлд нөлөөлөх сургалт” гэсэн нэр томъёог хэрэглэх.

<p>Албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага</p>	<p><b>5.2 дугаар зүйл. Ялын төрөл</b>  1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:  1.1. торгох ял;  1.2. нийтэд тусгай ажил хийлгэх ял;  1.3. зорчих эрхийг хязгаарлах ял;  1.4. хорих ял;  1.5. эрх хасах ял.  <b>11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх</b>  1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:  1.1. зодсон;  1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, гарчлаасан;  1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.  2. Энэ гэмт хэргийг:  2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;  2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;  2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>1. Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-т гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хоёр төрлийн ял ногдуулахаар заасан.  Гэтэл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албадан сургалтыг явуулах үүрэг хүлээсэн.  Зорчих эрх хязгаарлах ял шийтгэгдсэн этгээдэд эрүүгийн хуулиар зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагыг ял дээр нь нэмж хэрэглэж болохоор заасан байна.  Өөрөөр хэлбэл зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн этгээдэд зан үйлээ засах сургалтыг ямар байгууллага хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй байна.  Эрүүгийн хуулийн ялын төрлөөс баривчлах ял хасагдсан тул зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баривчлах шийтгэлийг хэрэгжүүлэх асуудлыг цагдаагийн байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага давхар хариуцуулж байгаа нь хүндрэл учруулж байна.</p>	<p>Баривчлах шийтгэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хариуцуулах, хуулийн заалтыг тодорхой болгох.</p>
--	--	---	---

<p>Албадан сургалтад хамруулах шийтгэл</p>	<p>Зөрчлийн тухай хууль</p> <p>4.5 дугаар зүйл.Албадан сургалт</p> <p>1.Энэ хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.</p> <p><b>ЭРҮҮГИЙН ХУУЛЬ</b></p> <p>Албадлагын арга хэмжээний төрөл</p> <p>1.Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно:</p> <p>1.1.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;</p> <p>7.3 дугаар зүйл.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ</p> <p>2.2.зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах;</p>	<p>Эрүүгийн хууль болон зөрчлийн хуульд албадан сургалт нь албадлагын арга хэмжээний нэг төрөл байхаар заасан бөгөөд харин гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд албадан сургалтанд хамруулах шийтгэл гэсэн агуулгаар зохицуулагдаж хуулийн заалтууд зөрүүтэй ойлгогдох байдал хүргэж байна.</p>	<p>Шинээр батлагдсан хуулиудтай нийцүүлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан зарим нэр томьёог нэг мөр болгох.</p>
<p>Баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна</p>	<p><b>ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ</b></p> <p>144 дүгээр зүйл. Баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх нийтлэг үндэслэл</p> <p>144.1.Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ.</p>	<p>Практикт нэг төрлийн зөрчил гаргасан этгээдэд баривчлах шийтгэл, албадан сургалтад хамруулах шийтгэврийн биелэлтийг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даалгаж байгаа нь хүндрэл учруулж байна.</p> <p>Баривчлагдсан этгээдийн зан зүйлд нөлөөлөх сургалт явуулах үүргийг нэг</p>	<p>Баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бие даан хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хуулиар бүрдүүлэх.</p>

	<p><b>ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ</b></p> <p>9.3 дугаар зүйл.Шүүгчийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх</p> <p>2.Энэ хуулийн 9.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.3 дахь заалтад заасан үндэслэлээр шүүгчийн хянан шийдвэрлэсэн, мөн баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага биелүүлнэ.</p>	<p>мөр нэг байгууллагад хариуцуулах шаардлагатай байна.</p> <p>Энэ нь сургалтын орчин, боловсон хүчин төсөв, хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэхболомжийг нэмэгдүүлэх юм.</p>	
--	---	---	--

### Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 Хүснэгт 9.

44.5-Т байгаа агуулга	Хууль хоорондын уялдаа зөрчил	Тулгарч буй бэрхшээл, асуудал	Шийдвэрлэх асуудал
Зан үйлд нөлөөлөх	<p>ЭРҮҮГИЙН ХУУЛЬ</p> <p>7.3 дугаар зүйл.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ</p> <p>2.2. Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах;</p> <p>ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>189 дүгээр зүйл.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх</p> <p>189.11.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт</p>	<p>Зан үйлээ засах сургалт гэдэг нь сургалтын оролцогч төвтэй байна, зан зүйлд нөлөөлөх гэдэг нь сургалтыг хэрэгжүүлэгч байгууллага буюу багш төвтэй сургалт байна.</p> <p>Тодруулвал, Хуульд зан зүйлд нөлөөлөх, зан үйл засах гэсэн 2 өөр нэр томъёогоор тусгасан байна.</p> <p>Мөн зан үйлээ засах сургалтын хөтөлбөр, журам эсхүл зан үйлийг өөрчлөх сургалтын журам, хөтөлбөр гэж байх, хуулийг хэрэгжүүлэх, сургалтын зорилгыг тодорхойлоход хүндрэл үүсгэж байна.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн уг заалтыг шинэчлэн найруулах, холбогдох хуулиудын нэр томьёо, агуулгыг нэг мөр болгох,</p> <p>“Зан үйлд нөлөөлөх сургалт” гэсэн нэр томьёог эрүүгийн хуульд шинээр зөрчлийн хуульд заасан албадан сургалтын зохицуулалтын агуулгаар тусгах. Жишээ нь</p>

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Застийн газрын гишүүн батална	явуулах мэргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна.		сургалтын үргэлжлэх дээд, доод хугацааг зөрчлийн хуульд заасны адил 10-50 цаг гэж оруулж байхаар
Зан үйлд нөлөөлөх хууль зүйн асуудал эрхэлсэн Застийн газрын гишүүн батална	ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ 189 дүгээр зүйл. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх 189.12. Сургалт явуулах журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.	ШШГБ агуулгын хувьд өргөн хүрээнд сургалт явуулах журмыг ШШГБ-ын дарга батлах нь зөв хэдий ч агуулгын давхардалгүй журам, хөтөлбөр батлах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг ХЗДХЯ-ны сайд баталсан байхад агуулгын давхардалтай журам, хөтөлбөр батласан байна.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийн бусад агуулгын хүрээнд журам, хөтөлбөр батлах замаар хуулийн хэрэгжилтэд анхаарах шаардлагатай байна.

### Сургалтын хөтөлбөр, гарын авлага арга зүйн материал Хүснэгт 10.

№	Нэр	Байгууллага	Агуулга	Зорилтот бүлэг
1	Зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааны үйл ажиллагааг төлөвлөх /гарын авлага/ 2006	НҮБ-ын хүн амын сан	Зан үйлийг өөрчлөх харилцааны талаар үр дүн дээр суурилсан хөтөлбөрийн хүрээний зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааг төлөвлөх, үнэлэх, зааварчлага	Энэ чиглэлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх цогц арга хэмжээний талаар арга зүйг сургалтад ашиглах.
2	Сэтгэл зүй, оюун санааны эмчлэгээний хөтөлбөр 2009 /Минесота загвар/	Эрүүл мэндийн яам /сэтгэцийн эрүүл мэндийн нэгдсэн төв/	Архины шалтгаант сэтгэц зан үйлийн эмгэг	Архинд донтох өвчтэй хүмүүст зориулсан сургалты зохион байгуулах.

3	Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамж /нотолгоонд суурилсан аргачлал/ 2018	НҮБ-ын боловсрол шинжлэх ухааны байгууллага	Бэлгийн цогц боловсролын талаарх цогц ойлголт мэдээлэл үнэлгээ Үндсэн ухагдхуун сэдэв болон суралцахуйн зорилт үр дүнгийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ	Сургалтын хөтөлбөр боловсруулах хяналт-шинжилгээ үнэлгээ хийх арга зүйн болон бэлгийн чиглэлээр мэдлэг олгоход ашиглах
4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр 2011	IDLO Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага	Чадавхжуулах сургалтын хөтөлбөр	- Сургалтын хөтөлбөр, танилцуулга - Хөтөлбөрийн агуулга - Цогц ажигчдад зориулсан хөтөлбөр - Практикт зориулсан хөтөлбөр
5	Өөрийгөө өөрчилье /гарын авлага/	Хууль зүй дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	Гэр бүл, архины хор хөнөөл, стресс болон сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх тухай	Сургалтын хөтөлбөр боловсруулах болон сургагч багш нар сургалтанд хэрэглэгдэхүүн болгон ашиглах
6	Үр нөлөө бүхий бодлогын баримт бичгийг боловсруулах нь /тев ба зүүн азийн орнуудын бодлогын зөвлөхүүдэд зориулсан гарын авлага/ 2003	Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, орон нутгийн засаглал ба төрийн үйлчилгээний шинэчлэлийн санаачилга	Төрийн үйлчилгээний шинэчлэлийн хүрээнд үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэхэд анхаарах, зөвлөмж болгосон гарын авлага	Бодлогын хэмжээнд сургалтын журам хөтөлбөр боловсруулахад хэрэглэх
7	Сургагч багшийн гарын авлага 2018	Хууль зүй, дотоод хэргийн яам	Архины үр нөлөө, эрүүл мэндийн боловсрол, стрессыг даван туулах арга замын талаарх зөвлөгөө	Сургалтын хөтөлбөр боловсруулах болон сургагч багш нар сургалтанд хэрэглэгдэхүүн болгон ашиглах

Дээрх хүснэгтийг дүгнэж үзвэл зан үйлд нөлөөлөх сургалтын жишиг хөтөлбөр, хөтөлбөр датгасан сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүнийг боловсруулахад эх сурвалж болох сайн туршлага, дотоод нөөц бололцоог ашиглаж хамтран ажиллах боломж байгааг харуулж байна.

## Сургалтын цагийн зохицуулалт

### Хүснэгт 11.

№	Хууль тогтоомж	Зохицуулалт
1	Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал 2017.04.04 А/73 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр	Хичээлийн цаг /60 минут/ - Сэтгэл зүйн сургалтанд 8 агуулга багтсан /16-41/ - Эрх зүйн сургалт 6 хууль /5-10/ - Бясалгалын сургалт /2-5/ Сургалтын нийт цаг 23-56 цаг - Нэг удаагийн сургалтын үргэжилгээ дундаж хугацаа 45 минутаас ихгүй - Шаардлагатай тохиолдолд бүлгийн сургалт 90 минутаас ихгүй байх
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал 2018.02.28 журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Сургалтын 4 цагийг 1 багц цагт тооцох, нэг удаагийн сургалтын үргэжилгээ хугацаа 90 минутаас дээшгүй байна. Орлоцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн шинж, албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг харгалзан хэд хэдэн сургалтыг хослуулан явуулж болно. Үүнд: а/ хууль, эрх зүйн сургалт 10 цаг б/ нийгмийн ажлын үйлчилгээ болон сэтгэл зүйн сургалт 5 в/ гэр бүлийн болон амьдрах ухааны боловсрол олгох сургалт 35 цаг минут
3	421 дүгээр нээлттэй хорих ангийн даргын баталсан “Албадан сургалтын хөтөлбөр”	Үндсэн сургалтын нийт цаг. Үүнээс. Цаг 36 үүнээс: - Лекц 12 цаг - Сэтгэл судлал 22 цаг - Семинар 2 цаг
4	Зөрчлийн тухай хууль	Албадан сургалт 10-50 цагийн хугацаатай байна.

## Албадан сургалтын талаарх хуулийн зохицуулалт

Хуулийн нэр, холбогдох зүйл	Зөрчлийн төрөл	Агуулга
Зөрчлийн тухай хууль 5.1	Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	Мансуурсан бол
Зөрчлийн тухай хууль 5.2	Танхайрах Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	Олон нийтийн газарт: - Хөрүүл маргаан үүсгэж; - Бусдыг өдөөн хатгаж; - Бусдын амгалан тайван байдал алдагдуулж; - Олон нийтийг үл хүндэтгэж; үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол
Зөрчлийн тухай хууль 5.4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: • зодсон; • хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; • бусадтай харилцахыг хязгаарласан; • хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол
Зөрчлийн хууль 8.6	Хулгайлах	• Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол
Зөрчлийн хууль 8.7	Хөрөнгө завших	• Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол
Зөрчлийн тухай хууль 14.7.5	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол



## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Хууль, хуульчилсан акт

- Монгол Улсын Үндсэн хууль 1992
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016
- Зөрчлийн тухай хууль 2017
- Эрүүгийн хууль 2017
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017
- Прокурорын тухай хууль 2017
- Хүүхэд хамгааллын тухай хууль 2016
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2016
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр 2017
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” 2017.09.20 №270
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ны өдрийн А/73-р тушаал
- ХЗДХ-ын сайдын А/25 дугаар тушаал “Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам 2017

### Судалгаа, мэдээлэл, тайлан

- Шүүхийн судалгаа, мэдээллийн хүрээлэн “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан” УБ., 2015, 2016, 2017, 2018
- Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг” УБ., 2017, 2018, 2019
- Үндэсний статистикийн хороо “Гэмт хэрэг” УБ., 2016, 2017, 2018
- Шүүхийн судалгаа, мэдээллийн хүрээлэн “Монгол Улсын шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан” УБ., 2018
- Зураг 1. Хамрагдсан аймаг, дүүрэг
- Зураг 2. Нөхцөл байдал
- Зураг 3. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо
- Зураг 4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон эмэгтэйчүүд, хүүхдийн тоо
- Зураг 5. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсний улмаас баривчлагдсан этгээдүүдийн тоо
- Зураг 6. Хүчирхийлэл үйлдэгчийн нас
- Зураг 7. Хүчирхийлэл үйлдэгчийн боловсролын түвшин

- Зураг 8. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийн тоо
- Зураг 9. Хохирогчийн мэдээлэл
- Зураг 10. Хүчирхийлэл үйлдэгчийн мэдээлэл
- Зураг 11. Цагдаагийн байгууллагын албадан сургалт явуулж буй өрөөг харьцуулсан байдал
- Зураг 12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албадан сургалт явуулж буй өрөөг харьцуулсан байдал
- Зураг 13. Сургалтын хэрэглэгдэхүүн
- Зураг 14. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй эсэх
- Зураг 15. Сургалтын үр дүнгийн талаар сургалтад хамрагдсан этгээдээс авсан судалгаа
- Зураг 16. Сургалтад ойлгомжгүй байсан зүйл
- Зураг 17. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан этгээдүүдийн сургалтад өгсөн үнэлгээ
- Зураг 18. Сургалтад үнэлгээ хийдэг байдал
- Хүснэгт 1. Хамарсан хүрээ, түүвэрлэлт
- Хүснэгт 2. Урьдчилан сэргийлэх, мэдээлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх чиг үүрэгтэй байгууллага, албан тушаалтан
- Хүснэгт 3. Сургалт зохион байгуулах, явуулах чиг үүрэгтэй байгууллага.
- Хүснэгт 4. Хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага.
- Хүснэгт 5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, санхүүжилт
- Хүснэгт 6. Ажлын байрны тодорхойлолтонд тусгах, хяналт тавих үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан
- Хүснэгт 7. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ
- Хүснэгт 8. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04 дугаар сарын 04-ны өдрийн А/73 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
- Хүснэгт 9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйл 44.4
- Хүснэгт 10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5
- Хүснэгт 11. Сургалтын хөтөлбөр, гарын авлага арга зүйн материал
- Хүснэгт 12. Сургалтын цагийн зохицуулалт
- Хавсралт 1. Албадан сургалтын талаарх хуулийн зохицуулалт